

**“ИНКОТЕРМС-2010”**  
**“БҮХ ТӨРЛИЙН ТЭЭВЭРТ АШИГЛАГДАГ НӨХЦЛҮҮД”**

**I. EXW-Ex Works (named place) буюу EXW-үйлдвэрээс (нэрлэсэн газар )**

Энэ нөхцлөөр худалдагч/экспортлогч/ үйлдвэрлэгч нь ачаа барааг худалдагчийн “нэрлэсэн газарт” худалдан авагчийн мэдэлд хүлээлгэн өгнө.Худалдагчийн нэрлэсэн газар нь худалдагчийн зөвшөөрсөн газар байх бөгөөд түүний агуулах, үйлдвэрийн газрын аль нэг байж болно.

Тус нөхцлийг тээврийн бүх төрөлд болон холимог тээвэрт ашиглах бөгөөд голчлон дотоодын худалдаанд түлхүү ашигладаг, дотоодын худалдаанд ашиглахад илүү тохиромжтой нөхцөл юм.

Талууд ачаа барааг нийлүүлэх нэрлэсэн газрыг нарийн тохиролцож, түүндээ тодорхой нэг цэгийг онцлон зааж тэр цэг хүртлэх зардал ,эрсдлийг худалдагч хариуцахаар эсвэл худалдагч ачаа барааг тээврийн хэрэгсэлд ачих зардал, эрсдлийг хариуцахаар хоорондоо тохиролцож болно.Энэ нөхцлийн дагуу худалдагчийн үүрэг маш бага, худалдан авагчийн үүрэг маш их байдаг.

**EXW нөхцөлөөр худалдагч болон худалдан авагч дараах үүрэг хариуцлагыг хүлээнэ.**

**1. Худалдагчийн үүрэг хариуцлага.**

**1.1. Худалдагчийн ерөнхий үүрэг хариуцлага**

Худалдагч нь худалдааны гэрээний дагуу бараа, барааны худалдааны нэхэмжлэх болон бусад шаардлагатай баримт бичгүүдийг шилжүүлнэ.Худалдагч, худалдан авагч талууд хүлээн зөвшөөрсөн болон худалдааны практик заншлын дагуу бичиг баримтуудыг электрон байдлаар шилжүүлж болно.

**1.2. Лиценз , зөвшөөрөл, аюулгүй гаалийн бүрдүүлэлт болон бусад дүрэм журмууд**

Худалдагч нь худалдан авагчийн хүсэлтээр, түүний зардал, эрсдлээр барааг экспортлоход шаардагдах зөвшөөрөл, лиценз болон бусад шаардлагатай бичиг баримтуудыг авахад бүхий л туслалцааг үзүүлнэ.

**1.3. Тээвэрлэлтийн болон даатгалын гэрээ, хэлэлцээр**

a) Тээврийн гэрээ

Худалдагч нь худалдан авагчид ачаа барааг тээвэрлэж хүлээлгэх ямар ч үүрэггүй.Өөрөөр хэлбэл тээврийн гэрээг байгуулахгүй.

b) Даатгалын гэрээ

Худалдагч нь худалдан авагчид даатгалын гэрээг байгуулах ямар ч үүрэггүй.Гэхдээ худалдан авагчийн хүсэлтээр, түүний зардал эрсдлээр даатгалын гэрээ байгуулж, даатгал хийлгэхэд шаардлагатай бүхий л мэдээллийг олж авахад нь худалдан авагчид туслах үүрэгтэй.

1.4. *Нийлүүлэлт*

Худалдагч нь ачаа барааг тохиролцсон нэрлэсэн нийлүүлэх газар<sup>1</sup>-т тээврийн хэрэгсэлд ачаалаагүй байдлаар гэрээнд заасан хугацаанд худалдан авагчид шилжүүлнэ. Хэрэв нэрлэсэн нийлүүлэх газрын тодорхой цэгийг тохиролцож чадаагүй (үйлдвэрээс эсвэл агуулахаас эсвэл хуваарилалтын сувгийн аль боломжит цэг) хэд хэдэн боломжит цэгүүд байгаа тохиолдолд худалдагч өөрт хамгийн тохиромжтой газрыг сонгож нийлүүлэлтийг хийнэ.

1.5. *Эрсдэл шилжих*

Худалдагч нь ачаа барааг гэрээнд заасан хугацаанд нэрлэсэн нийлүүлэх газарт шилжүүлэх хүртэл ачаа бараанд учирч болох аливаа алдагдал, эвдрэл гэмтлийн бүх эрсдлийг хариуцна.

1.6. *Зардал хуваарилалт*

Худалдагч нь ачаа барааг гэрээнд заасан хугацаанд нэрлэсэн нийлүүлэх газарт шилжүүлэх хүртлэх бүх зардлыг хариуцаж, төлөх үүрэгтэй.

1.7. *Худалдан авагчид мэдэгдэх*

Худалдагч нь ачаа барааг хүлээн авахтай холбоотой шилжүүлэх газар, хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг худалдан авагчид мэдээлэх үүрэгтэй.

1.8. *Нийлүүлэлтийн бичиг баримт*

Худалдагч нь худалдан авагчид нийлүүлэлтийн нотолгоо, баримт өгөх ямар ч үүрэггүй.

#### 1.9. Хянах, савлах, хаяг шошгожуулах

Худалдагч нь гэрээний дагуу ачаа барааг нийлүүлэхэд шаардагдах хяналт шалгалтын үйл ажиллагаа (үүнд: барааны тоо хэмжээ, чанарыг шалгах, үнэлэх, жинлэх, тоолох) –ны зардлуудыг төлөх үүрэгтэй. Сав, баглаа боодлогүйгээр зарагдах барааг тээвэрлэх онцгой худалдаа биш л бол худалдан авагч тээвэрлэлтийн нөхцөл, тээврийн төрлийг урьдчилан хэлсний дагуу (тээврийн төрлийн онцгой хэрэгцээ шаардлага гараагүй л бол) худалдагч барааны сав баглаа боодлыг хариуцна. Сав баглаа боодолд тохирсон хаяг шошгыг хадна.

#### 1.10. Мэдээллийн тусламж, холбогдох зардлууд

Худалдагч нь худалдан авагчийн хүсэлтээр түүний зардал, эрсдлээр экспорт, импортын үйл ажиллагаа болон ачаа бараа хүрэх эцсийн цэг (нийлүүлэх нэрлэсэн газар<sup>2</sup>) хүртэл тээвэрлэлтэд шаардлагатай, аюулгүй байдалтай холбоотой бусад мэдээллийг болон шаардлагатай бичиг баримтыг өгөх үүрэгтэй.

### 2. Худалдан авагчийн үүрэг хариуцлага

#### 2.1. Худалдан авагчийн ерөнхий үүрэг хариуцлага

Худалдан авагч нь худалдааны гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу ачаа барааны үнийг төлөх үүрэгтэй. Худалдагч, худалдан авагч талууд хүлээн зөвшөөрсөн болон худалдааны практик заншлын дагуу бичиг баримтуудыг электрон байдлаар шилжүүлж болно.

#### 2.2. Лиценз, зөвшөөрөл, аюулгүй гаалийн бүрдүүлэлт болон бусад дүрэм журмууд

Худалдан авагч нь барааг экспортлох/ импортлоход шаардагдах зөвшөөрөл, лиценз болон бусад шаардлагатай бичиг баримтуудын бүх зардал, эрсдлийг өөрөө хариуцна. Экспорт, импортын гаалийн бүрдүүлэлтийг өөрийн зардал, эрсдлээр хариуцна.

#### 2.3. Тээвэрлэлтийн болон даатгалын гэрээ, хэлэлциээр

a) Тээврийн гэрээ

Худалдан авагч нь худалдагчаар ачаа барааг тээвэрлүүлэх үүрэггүй.Өөрөөр хэлбэл тээврийн гэрээг өөрөө байгуулж, тээврийн зардлыг хариуцна.

b) Даатгалын гэрээ

Худалдан авагч нь даатгалын гэрээг хийх ямар ч үүрэггүй. Гэхдээ даатгал хийлгэхээр болсон тохиолдолд өөрийн зардлаар даатгал хийлгэхэд шаардлагатай бүхий л мэдээллийг олж авч, даатгалын гэрээг байгуулж болно.

2.4. *Нийлүүлэлтийг хүлээн авах*

Худалдааны гэрээнд заасан хугацаанд нэрлэсэн газраас барааны нийлүүлэлтийг хүлээн авах үүрэгтэй.

2.5. *Эрсдэл шилжих*

Худалдааны гэрээгээр тохиролцсон хугацаанд, нэрлэсэн газраас ачаа барааг хүлээн авсан үеэс эхлэн ачаа барааны алдагдал, эвдрэл гэмтлийн аливаа эрсдлийг бүрэн хариуцна.Хэрэв худалдан авагч энэ дүрмийн 2.7 –д заасны дагуу мэдэгдлийг өгөөгүй тохиолдолд барааны нийлүүлэлтийг хийхээр тохиролцсон хугацаа дуусах өдөр эсвэл тодорхой нарийн заасан өдрөөс барааны алдагдал, эвдрэл гэмтлийн аливаа бүх эрсдлийг хариуцна.

2.6. *Зардал хуваарилалт*

Худалдан авагч дараах зардлуудыг хариуцна. Үүнд:

- a. Гэрээгээр урьдчилан тохиролцсоны дагуу ачаа барааг худалдагчаас хүлээн авсан цагаас эхлэн ачаа бараатай холбоотой ачих, буулгах, тээвэрлэх зэрэг тээвэрлэлт, даатгалын бүх зардлыг төлнө.
- b. Гэрээнд заасан хугацаанд ачаа барааны нийлүүлэлтийг хүлээн аваагүйгээс учирсан хохирлыг хариуцаж, үүнээс шалтгаалсан нэмэлт бүх зардлыг төлнө.
- c. Экспорт, импортын гаалийн татвар, бусад хураамжууд, экспорт импортын үзлэг шалгалтын бүх зардлыг төлнө.
- d. Экспортын гаалийн бүрдүүлэлтийг хийлгүүлсний зардлыг худалдагчид төлнө.

## **2.7. Худалдагчид мэдээлэх**

Нэрлэсэн нийлүүлэх газраас тохиролцсон цэг, тохиролцсон хугацаанд барааны нийлүүлэлтийг хүлээн авахыг худалдагчид мэдэгдэнэ.

## **2.8. Нийлүүлэлтийг хүлээн авсны нотолгоо**

Барааны нийлүүлэлтийг хүлээн авснаа худалдагчид нотолно.

## **2.9. Ачаа барааг шалгах**

Экспортын улсын эрх бүхий байгууллагын шаардлагын дагуу тээврийн хэрэгсэлд ачаалахаас өмнө хийгдэх шалгалтын зардлыг төлнө.

## **2.10. Мэдээллийн тусламж, холбогдох зардлууд**

Ачаа барааны аюулгүй байдалтай холбоотой аливаа мэдээллийг худалдагчаас авах бөгөөд худалдагчаас экспорт, импортын үйл ажиллагаанд шаардагдах экспортын орны гарах бичиг баримтыг гаргуулсны зардлыг худалдагчид төлнө.

## **II. FCA-Free Carrier (named place) буюу FCA-Тээвэрлэх хүртэл чөлөөтэй (нэрлэсэн газар )**

Энэ нөхцөлөөр худалдагч/экспортлогч/ үйлдвэрлэгч нь ачаа барааг худалдагчийн зөвшөөрсөн “нэрлэсэн нийлүүлэх газар”-т эсвэл тохиролцсон өөр нэрлэсэн газарт худалдан авагчийн нэрлэсэн тээвэрлэгч эсвэл түүний санал болгосон гуравдагч этгээдийн мэдэлд хүлээлгэн өгнө. Талууд нэрлэсэн газрын ачаа барааг нийлүүлэх цэгийг нарийн тодорхойлж чадвал тэр цэг дээр эрсдэл худалдан авагчид шилжих болно.Хэрэв нэрлэсэн газар нь худалдагчийн агуулах, үйлдвэрийн газрын аль нэг байвал худалдагч барааг тээврийн хэрэгсэлд ачих үүрэг хүлээнэ.Харин нэрлэсэн газар нь түүнээс өөр газар байвал худалдагч барааг тээврийн хэрэгсэлд ачих үүрэг хүлээхгүй.

Тус нөхцлийг тээврийн бүх төрөлд болон холимог тээвэрт ашиглана.Өөрөөр хэлбэл тээвэрлэгч төмөр зам, авто зам, агаарын тээвэр, усан онгоц байж болно.

Энэ нөхцлийн дагуу худалдагчийн үүрэг нэрлэсэн тээвэрлэгчид барааг хүлээлгэн өгөх хүртэл нэмэгдэнэ.

**FCA нөхцөлөөрхудалдагчболон худалдан авагч дараах үүрэг хариуцлагыг хүлээнэ.**

## **1 Худалдагчийн үүрэг хариуцлага.**

### **1.1. Худалдагчийн ерөнхий үүрэг хариуцлага**

Худалдагч нь худалдааны гэрээний дагуу бараа, барааны худалдааны нэхэмжлэх болон бусад шаардлагатай баримт бичгүүдийг шилжүүлнэ.Худалдагч, худалдан авагч талууд хүлээн зөвшөөрсөн болон худалдааны практик заншлын дагуу бичиг баримтуудыг электрон байдлаар шилжүүлж болно.

### **1.2. Лиценз , зөвшөөрөл, аюулгүй гаалийн бүрдүүлэлт болон бусад дүрэм журмууд**

Худалдагч нь ачаа барааг экспортлоход шаардагдах гаалийн бүх баримт бичгүүд буюу экспортын гаалийн бүрдүүлэлтийн баримтууд, аливаа зөвшөөрөл, лиценз болон бусад шаардлагатай бичиг баримтуудыг өөрийн зардал, эрсдлээр хариуцна.

### **1.3. Тээвэрлэлтийн болон даатгалын гэрээ, хэлэлцээр**

#### **a) Тээврийн гэрээ**

Худалдагч нь худалдан авагчид ачаа барааг тээвэрлэж хүлээлгэх ямар ч үүрэггүй.Өөрөөр хэлбэл тээврийн гэрээг хийх үүрэггүй. Гэхдээ хэрэв худалдан авагч хүсвэл худалдагч худалдан авагчийн зардал эрсдлээр стандарт аж үйлдвэрийн нөхцлөөр тээвэрлэлтийн гэрээг хийж болно.Хэрэв ингэх бол худалдагч худалдан авагчид мэдэгдэнэ.

#### **b) Даатгалын гэрээ**

Худалдагч нь худалдан авагчид даатгалын гэрээг байгуулах ямар ч үүрэггүй. Гэхдээ худалдан авагчийн хүсэлтээр, түүний зардал эрсдлээр даатгалын гэрээ байгуулах, даатгал хийлгэхэд шаардлагатай бүхий л мэдээллийг олж авахад нь худалдан авагчид туслах үүрэгтэй.

### **1.4. Нийлүүлэлт**

Худалдагч барааг нэрлэсэн тээвэрлэгчид эсвэл худалдан авагчийн нэрлэсэн гуравдагч талд нэрлэсэн нийлүүлэх газарт гэрээнд дурдсан хугацаанд хүлээлгэж өгнө. Нийлүүлэлтийг гүйцэтгэхдээ:

- Хэрэв нэрлэсэн нийлүүлэх газар нь худалдан авагчтай тохиролцсон, түүний зөвшөөрсөн газар байх тохиолдолд худалдан авагчийн нэрлэсэн тээврийн хэрэгсэлд барааг ачих үүрэг хүлээнэ.
- Эсвэл үүнээс өөр газарт тохиролцвол ачаалахад бэлэн болсон барааг худалдан авагчийн нэрлэсэн тээвэрлэгч эсвэл түүний нэрлэсэн гуравдагч этгээдэд хүлээлгэж өгнө. Хэрэв худалдан авагч нь барааг хүлээн авах нэрлэсэн газрын аль нэг тодорхой цэгийг заагаагүй тохиолдолд боломжит хэд хэдэн цэгүүдээс хамгийн тохиромжтой нэг цэгийг худалдагч сонгон барааг тээвэрлэгчид хүлээлгэн өгнө. Талууд өөрөөр тохиролцоогүй л бол худалдагч нь барааг шаардлагатай тоо хэмжээгээр нь тээвэрлэгчид дээрх сонголтоор хүлээлгэж өгөх болно.

#### 1.5. Эрсдэл шилжих

Худалдагч нь ачаа барааг гэрээнд заасан хугацаанд нэрлэсэн нийлүүлэх газарт нэрлэсэн тээвэрлэгчид шилжүүлэх хүртэл ачаа бараанд учирч болох аливаа алдагдал, эвдрэл гэмтлийн бүх эрсдлийг хариуцна.

#### 1.6. Зардал хуваарилалт

Худалдагч дараах зардлуудын төлнө. Үүнд:

- Ачаа барааг гэрээнд заасан хугацаанд нэрлэсэн нийлүүлэх газарт нэрлэсэн тээвэрлэгчид хүргэж өгөхтэй холбоотой бүх зардлыг хариуцан төлнө. Өөрөөр хэлбэл нэрлэсэн нийлүүлэх газар хүртлэх дотоодын тээврийн зардал, худалдан авагчтай тохиролцсон тохиолдолд ачилтын зардлыг хариуцан төлнө.
- Экспортын татвар хураамж, гаалийн үзлэг шалгалт, гаалийн бүрдүүлэлттэй холбоотой бүх зардлыг хариуцаж, төлөх үүрэгтэй.

#### 1.7. Худалдан авагчид мэдэгдэх

Худалдагч нь ачаа барааг тээвэрлэгчид шилжүүлснээ худалдан авагчид мэдэгдэнэ. Мөн худалдан авагчийн эрсдэл, зардлаар түүнд барааны нийлүүлэлттэй холбоотой хангалттай мэдээллийг өгөх, түүнчлэн гэрээгээр тохирсон хугацаанд худалдан авагчийн нэрлэсэн тээвэрлэгч эсвэл гуравдагч этгээд нь барааг хүлээж аваагүй талаархи мэдээллийг өгөх үүрэгтэй.

#### 1.8. Нийлүүлэлтийн бичиг баримт

Худалдагч нь өөрийн зардлаар хариуцан худалдан авагчид нийлүүлэлтийн нотолгоо, баримт өгөх бөгөөд худалдан авагчийн эрсдэл, зардал, түүний

хүсэлтээр холбогдох тээвэрлэлтийн баримт бичгийг олоход худалдан авагчид туслалцаа үзүүлнэ

#### 1.9. *Шалгах, савлах, хаяг шошгожуулах*

Худалдагч нь гэрээний дагуу ачаа барааг нийлүүлэхэд шаардагдах хяналт шалгалтын үйл ажиллагаа (үүнд: барааны тоо хэмжээ, чанарыг шалгах, үнэлэх, жинлэх, тоолох) –ны зардлуудыг өөрөөр хэлбэл тээвэрлэхээс өмнөх экспортын улсын эрх бүхий байгууллагаас хийх хяналт шалгалтын зардлыг төлөх үүрэгтэй. Худалдагч нь сав баглаагүй зарагддаг барааг тээвэрлэх тусгай худалдаа биш л бол бараа бүтээгдэхүүний савлалтын зардлыг өөрөө хариуцна.Худалдан авагч худалдагчид тээвэрлэлтийн нөхцөл, тээврийн төрлийг урьдчилан хэлсний дагуу, худалдааны гэрээг дуусахаас өмнө савлалтын онцгой хэрэгцээ шаардлагыг худалдагчид мэдээлээгүй л бол ачаа барааны сав баглаа боодлыг тээвэрлэлтийн төрөлд тохируулан хийнэ.Сав баглаа боодолд тохирсон хаяг шошгыг хадна.

#### 1.10. *Мэдээллийн тусламж, холбогдох зардлууд*

Худалдагч нь худалдан авагчийн хүсэлтээр түүний зардал, эрсдлээр импортын болон транзит тээвэрлэлтэд шаардлагатай бичиг баримтыг өгөх үүрэгтэй.Худалдан авагчийн хүсэлтээр даатгал хийхэд шаардлагатай мэдээллийг өгнө.

Худалдагч нь худалдан авагчийн хүссэн мэдээлэл, баримт бичгийг олж авахад тусламж үзүүлэх, мэдээллээр хангахдаа худалдан авагчийн зарцуулсан бүх зардлыг шаардлагатай тохиолдолд буцаан нөхөн олгох ёстой.

### **2 Худалдан авагчийн үүрэг хариуцлага**

#### 2.1. *Худалдан авагчийн ерөнхий үүрэг хариуцлага*

Худалдан авагч нь худалдааны гэрээгээр тохиролцсны дагуу ачаа барааны үнийг төлөх үүрэгтэй.Худалдагч, худалдан авагч талууд хүлээн зөвшөөрсөн болон худалдааны практик заншлын дагуу бичиг баримтуудыг электрон байдлаар шилжүүлж болно.

#### 2.2. *Лиценз , зөвшөөрөл, аюулгүй гаалийн бүрдүүлэлт болон бусад дүрэм журмууд*

Худалдан авагч нь барааг импортлоход шаардагдах зөвшөөрөл, лиценз болон бусад шаардлагатай бичиг баримтуудын бүх зардал, эрсдлийг өөрөө хариуцна. Импортын гаалийн бүрдүүлэлтийг өөрийн зардал, эрсдлээр хариуцна.

### 2.3. Тээвэрлэлтийн болон даатгалын гэрээ, хэлэлцээр

#### a) Тээврийн гэрээ

Худалдан авагч нь ачаа барааг тээвэрлэхтэй холбоотой бүх үүргийг хариуцна, өөрөөр хэлбэл тээврийн гэрээг тээвэрлэгчтэй байгуулж, тээврийн зардлыг төлнө.

#### b) Даатгалын гэрээ

Худалдан авагч нь заавал даатгалын гэрээг хийх албагүй. Гэхдээ даатгал хийлгэхээр болсон тохиолдолд өөрийн зардлаар даатгал хийлгэхэд шаардлагатай бүхий л мэдээллийг олж авч, даатгалын гэрээг байгуулж болно.

### 2.4. Нийлүүлэлтийг хүлээн авах

Худалдааны гэрээнд заасан хугацаанд нэрлэсэн нийлүүлэх газраас барааны нийлүүлэлтийг хүлээн авах үүрэгтэй.

### 2.5. Эрсдэл шилжих

Худалдааны гэрээгээр тохиролцсон хугацаанд, нэрлэсэн нийлүүлэх газраас ачаа бараа тээвэрлэгчид очсон үеэс эхлэн ачаа барааны алдагдал, эвдрэл гэмтлийн бүх төрлийн эрсдлийг бүрэн хариуцна.

Хэрэв,

- a. Худалдан авагч нь гэрээнд заасан хугацаанд тээвэрлэгч эсвэл өөрийн нэрлэсэн гуравдагч этгээдийн талаархи мэдээллийг өгөөгүй,
- b. Тээвэрлэгч эсвэл өөрийн нэрлэсэн гуравдагч этгээд нь ачаа барааг хүлээж аваагүй бол худалдан авагч нь
  - i. Гэрээгээр тохиролцсон өдрөөс эсвэл ,
  - ii. Худалдагчийн санал болгосон өдөр эсвэл ,
  - iii. Нийлүүлэлтийг хүлээн авахаар тохиролцсон хугацаа дуусах өдрөөс эхлэн ачаа бараанд учрах бүх эрсдлийг хариуцна.

## *2.6. Зардал хуваарилалт*

Худалдан авагч дараах зардлуудыг хариуцна. Үүнд:

- a. Гэрээгээр урьдчилан тохиролцсоны дагуу ачаа бараа тээвэрлэгчид очсон үеэс эхлэн ачаа барааг нийлүүлэхтэй холбоотой бүх зардлыг төлнө.
- b. Гэрээнд заасан хугацаанд ачаа барааны нийлүүлэлтийг хүлээн аваагүйгээс учирсан хохирлыг хариуцаж, үүнээс шалтгаалсан нэмэлт бүх зардлыг төлнө.
- c. Тээвэрлэгчийн нэрийг хэлээгүйгээс учрах хохирлыг төлнө.
- d. Импортын гаалийн татвар, бусад хураамжууд, импортын үзлэг шалгалт, импортын гаалийн бүрдүүлэлтийн бүх зардлыг төлнө.

## *2.7. Худалдагчид мэдээлэх*

Худалдан авагч нь худалдагчид дараах зүйлүүдийг мэдээлэх үүрэгтэй. Үүнд:

- ✓ Худалдагчид тээвэрлэгчийн нэр,
- ✓ Нийлүүлэлтийн хугацаа,
- ✓ Тээврийн төрөл,
- ✓ Нийлүүлэх нэрлэсэн газарт нийлүүлэлтийг хүлээн авах эцсийн цэг,

## *2.8. Нийлүүлэлтийг хүлээн авсны нотолгоо*

Худалдагч барааг тээвэрлэгчид хүлээлгэж өгсөн тухай нотолгоог хүлээж авна.

## *2.9. Ачаа барааг шалгах*

Экспортын улсын эрх бүхий байгууллагаас хийдэг шалгалтаас гадна заавал хийгдэх ачаалахаас өмнөх хяналт шалгалтын зардлыг төлнө.

## *2.10. Мэдээллийн тусламж, холбогдох зардлуууд*

Ачаа барааны аюулгүй байдалтай холбоотой аливаа мэдээллийг худалдагчаас авах бөгөөд импортод шаардлагатай экспортын орны гаргах

баримт бичгийн зардлыг төлнө, худалдагчид тээвэрлэлттэй холбоотой зааварчилгааг өгнө.

Худалдан авагч нь өөрт шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг олж авахад тусламж үзүүлэх, мэдээллээр хангахад худалдагчийн гаргасан бүх зардлыг буцаан нөхөн олгох ёстой.

## **СРТ нөхцөлөөр худалдагч болон худалдан авагч дараах үүрэг хариуцлагыг хүлээнэ.**

### **1 Худалдагчийн үүрэг хариуцлага.**

#### **1.1. Худалдагчийн өрөнхий үүрэг хариуцлага**

Худалдагч нь худалдааны гэрээний дагуу бараа, барааны худалдааны нэхэмжлэх болон бусад шаардлагатай баримт бичгүүдийг шилжүүлнэ.Худалдагч, худалдан авагч талууд хүлээн зөвшөөрсөн болон худалдааны практик заншлын дагуу бичиг баримтуудыг электрон байдлаар шилжүүлж болно.

#### **1.2. Лиценз , зөвшөөрөл, аюулгүй гаалийн бүрдүүлэлт болон бусад дүрэм журмууд**

Худалдагч нь өөрийн зардал, эрсдлээр барааг экспортлоход шаардагдах зөвшөөрөл, лиценз болон бусад шаардлагатай бичиг баримтууд болон экспортын бүрдүүлэлтийг хариуцна.

#### **1.3. Тээвэрлэлтийн болон даатгалын гэрээ, хэлэлцээр**

##### **а) Тээврийн гэрээ**

Худалдагч ачаа барааг нийлүүлэх нэрлэсэн боомтын цэг дээрээс, нэрлэсэн очих боомтод хүлээлгэж өгөх газар эсвэл тэр боомт доторхи аливаа тохиролцсон цэг хүртэл ачаа барааг тээвэрлэх тээврийн гэрээг хийх үүрэгтэй.Тээврийн гэрээнд худалдагчийн зардлаар хийж гүйцэтгэх ажлууд, тээвэрлэгчийн тээврийн үйл ажиллагааг хийж гүйцэтгэх гол гол чиглэлүүдийг тусгана.Хэрэв тодорхой цэгийг заагаагүй бол худалдагч нийлүүлэлтийг хийх цэг, нэрлэсэн очих боомтод барааг хүргэх цэгийг өөрт хамгийн тохиромжтойгоор сонгох эрхтэй.

b) Даатгалын гэрээ

Худалдагч даатгал хийх болон даатгалын зардлыг төлөх үүрэггүй. Харин худалдан авагчид даатгал олж авахад нь шаардлагатай мэдээллээр хангах, тусlamж үзүүлэх үүрэгтэй.

1.4. *Нийлүүлэлт*

Гэрээнд заасан хугацаанд барааг тээвэрлэгчид хүлээлгэж өгнө.

1.5. *Эрсдэл шилжих*

Худалдагч нь ачаа барааг гэрээнд заасны дагуу тээвэрлэгчид хүлээлгэж өгөх хүртэл ачаа бараанд учирч болох аливаа алдагдал, эвдрэл гэмтлийн бүх эрсдлийг хариуцна.

1.6. *Зардал хуваарилалт*

Худалдагч дараах зардлуудыг хариуцна. Үүнд:

- a. Ачаа барааг гэрээнд заасан хугацаанд нэрлэсэн очих газар хүртэл хүргэх бараатай холбоотой бүх зардлууд
- b. Тээвэрлэлтийн гэрээг байгуулж, тээврийн хэрэгсэлд ачих, талууд тохиролцсон бол буулгах зардал, тээврийн зардал
- c. Экспортын татвар хураамж, гаалийн үзлэг шалгалт, экспортын гаалийн бүрдүүлэлттэй холбоотой бүх зардлыг хариуцаж, төлөх үүрэгтэй.

1.7. *Худалдан авагчид мэдэгдэх*

Худалдан авагчид барааг тээвэрлэгчид хүлээлгэж өгсөн тухайгаа мэдэгдэнэ. Бараа бүтээгдэхүүнийг хүлээн авахад худалдан авагчийн зүгээс хийх боломжтой, шаардлагатай авах арга хэмжээний талаар аливаа мэдээллийг өгөх үүрэгтэй.

1.8. *Нийлүүлэлтийн бичиг баримт*

Худалдагч нь худалдан авагчид нийлүүлэлт, тээвэрлэлтийн баталгаа нотолгоо буюу тээвэрлэлтийн баримт бичгийг өгнө. Тээврийн энэхүү баримт нь худалдааны гэрээнд тусгагдсан байх ёстой бөгөөд барааны нийлүүлэлтийг хүлээн авах хугацааны дотор худалдан авагчид шилжих ёстой. Ингэснээр худалдан авагч нь тээвэрлэлтийн баримт бичгийг шилжүүлэх буюу тээвэрлэгчид мэдэгдэх замаар транзит замд нь худалдах

боломжтой болно. Энэ тээврийн баримтыг гэрээ байдлаар, хэд хэдэн эх хувиар үйлдэх бөгөөд бүх л эх хувиудыг худалдан авагчид танилцуулах ёстой.

#### 1.9. Хянах, савлах, хаяг шошгожуулах

Худалдагч нь гэрээний дагуу ачаа барааг нийлүүлэхэд шаардагдах хяналт шалгалтын үйл ажиллагаа (үүнд: барааны тоо хэмжээ, чанарыг шалгах, үнэлэх, жинлэх, тоолох) –ны зардлуудыг төлөх үүрэгтэй. Ингэхдээ худалдан авагч худалдагчид тээвэрлэлтийн нөхцөл, тээврийн төрлийг урьдчилан хэлсний дагуу (тээврийн төрлийн онцгой хэрэгцээ шаардлага гаралт бол) худалдагч барааны сав баглаа боодлыг хариуцна. Сав баглаа боодолд тохирсон хаяг шошгыг хадна.

#### 1.10. Мэдээллийн тусламж, холбогдох зардлууд

Худалдагч нь худалдан авагчид түүний эрсдэл, зардлаар импортын болон транзит тээвэрлэлтэд шаардлагатай гарал үүслийн бичиг баримтыг гаргаж өгөх үүрэгтэй. Худалдан авагчийн хүсэлтээр нэмэлт даатгал хийхэд шаардлагатай мэдээллийг өгнө.

## 2 Худалдан авагчийн үүрэг хариуцлага

#### 2.1. Худалдан авагчийн өрөнхий үүрэг хариуцлага

Худалдан авагч нь худалдааны гэрээг бүрэн төгс ханган биелүүлэхийн тулд ачаа барааны үнийг төлөх үүрэгтэй.

#### 2.2. Лиценз, зөвшөөрөл, аюулгүй гаалийн бүрдүүлэлт болон бусад дүрэм журмууд

Худалдан авагч нь барааг импортлоход шаардагдах зөвшөөрөл, лиценз болон бусад шаардлагатай бичиг баримтуудын бүх зардал, эрсдлийг өөрөө хариуцна. Импортын гаалийн бүрдүүлэлтийг өөрийн зардал, эрсдлээр хариуцна.

#### 2.3. Тээвэрлэлтийн болон даатгалын гэрээ, хэлэлциэр

Худалдагчийн өмнө тээвэрлэлт болон даатгалын ямар нэг үүрэг хүлээхгүй. Гэхдээ худалдан авагч даатгалыг хийлгэхийг хүсвэл өөрийн эрсдэл зардлаар хариуцна.

#### 2.4. *Нийлүүлэлтийг хүлээн авах*

Худалдааны гэрээнд заасан хугацаанд барааны нийлүүлэлтийг нийлүүлэх нэрлэсэн боомтоос тээвэрлэгчээс хүлээн авах үүрэгтэй.

#### 2.5. *Эрсдэл шилжих*

Барааг ачаалсан боомтоос тээвэрлэгчид хүлээлгэн өгсөн үеэс эхлэн ачаа барааны алдагдал, эвдрэл гэмтлийн аливаа эрсдлийг бүрэн хариуцна.Хэрэв бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийг хүлээн авах газар, хугацааг тодорхой заасан мэдээллийг худалдагчид өгөөгүй бол гэрээнд заасан барааг нийлүүлэх өдрийн хамгийн сүүлчийн өдрөөс эхлэх ачаа барааны бүх эрсдлийг хариуцах үүрэгтэй.

#### 2.6. *Зардал хуваарилалт*

Худалдан авагч дараах зардлуудыг хариуцна. Үүнд:

- a. Гэрээгээр урьдчилан тохиролцсоны дагуу ачаа бараа эхний тээвэрлэгчид хүлээлгэж өгснөөс эхлэн нэрлэсэн очих газар хүртлэх холбогдох бүхий л нэмэлт зардлууд
- b. Тээврийн гэрээгээр худалдагчийн хариуцахаар тусгасан зардлуудаас бусад бараа бүтээгдэхүүнийг очих боомтод хүлээн авах болон транзит тээвэрлэлттэй холбогдох зардлууд
- c. Очих боомтонд буулгах, жинлэх болон холбогдох бүхий л нэмэлт зардлууд
- d. Барааны нийлүүлэлтийг гэрээгээр тохирсон газар, хугацаанд хүлээж аваагүйгээс үүдэн гарах аливаа зардлууд
- e. Импортын гаалийн татвар, бусад хураамжууд, импортын үзлэг шалгалтын бүх зардлыг төлнө.Импортын гаалийн бүрдүүлэлтийг хариуцна.

#### 2.7. *Худалдагчид мэдээлэх*

Хэрэв гэрээний дагуу худалдан авагч ачаалах хугацааг тодорхойлж буюу очих боомтыг заах боломжтой бол худалдагчид зохих мэдээллийг өгнө.

## *2.8. Нийлүүлэлтийг хүлээн авсны нотолгоо*

Худалдагчаас өгөх нийлүүлэлтийн буюу тээвэрлэлтийн баримт бичгийг хүлээн авна.

## *2.9. Ачаа барааг шалгах*

Экспортын улсын эрх бүхий байгууллагын шаардлагын дагуу тээврийн хэрэгсэлд ачаалахаас өмнө хийгдэх шалгалтын зардлыг төлнө.

## *2.10. Мэдээллийн туссламж, холбогдох зардлууд*

Импортлоход шаардлагатай экспортын болон гарал үүслийн баримт бичгийг авах бүх төлбөрийг төлнө.Худалдагчид ийм баримт бичиг гаргасны төлөө төлбөр төлнө.

## **III. CIP –Carriage and Insurance Paid To (named port of destination) буюу CIP- Даатгал ба Тээвэрлэлт төлөгдсөн (нэрлэсэн очих/хүрэх боомт )**

Энэ нөхцөлөөр худалдагч/экспортлогч/ үйлдвэрлэгч нь ачаа барааг өөрийн нэрлэсэн тээвэрлэгчээр “нийлүүлэх нэрлэсэн газар буюу нэрлэсэн очих/хүрэх боомт” хүртэл хүргэж өгнө.Нэрлэсэн очих/хүрэх боомт нь худалдан авагчийн улсын газар байх бөгөөд энэ нь нийлүүлэлтийн эцсийн цэг байх албагүй.

Тус нөхцлийг тээврийн бүх төрөл болон холимог тээвэрт хэрэглэнэ.

Тээвэрлэгч нь усан онгоц, агаарын тээвэр, төмөр зам, авто тээвэр байж болно.Хэрэв хэд хэдэн тээвэрлэгч байгаа бол барааг эхний тээвэрлэгчид хүлээлгэж өгснөөр эрсдэл шилжинэ.Худалдагч тээвэрлэлтийн туршид ачаа бараанд учрах эвдрэл гэмтэл, барааны алдагдал зэрэгтэй холбоотой худалдан авагчийн эрсдлүүдийг багтаасан даатгалын гэрээг байгуулах үүрэгтэй.Худалдан авагч CIP нөхцлөөр худалдагчид бага хэмжээний даатгалын эрсдлүүдийг нэрлэж болно.Хэрэв худалдан авагч их хэмжээний эрсдлийг даатгуулахыг хүсвэл худалдагчтай энэ талаар нарийн тохиролцох, эсвэл өөрөө нэмэлт даатгалын гэрээг байгуулж болно.

**CIP нөхцөлөөр худалдагч болон худалдан авагч дараах үүрэг хариуцлагыг хүлээнэ.**

### **1. Худалдагчийн үүрэг хариуцлага.**

#### *1.1. Худалдаагчийн ерөнхий үүрэг хариуцлага*

Худалдагч нь худалдааны гэрээний дагуу бараа, барааны худалдааны нэхэмжлэх болон бусад шаардлагатай баримт бичгүүдийг шилжүүлнэ.Худалдагч, худалдан авагч талууд хүлээн зөвшөөрсөн болон худалдааны практик заншлын дагуу бичиг баримтуудыг электрон байдлаар шилжүүлж болно.

**1.2. Лиценз , зөвшөөрөл, аюулгүй гаалийн бүрдүүлэлт болон бусад дүрэм журмууд**

Худалдагч нь өөрийн зардал, эрсдлээр барааг экспортлоход шаардагдах зөвшөөрөл, лиценз болон бусад шаардлагатай бичиг баримтууд болон экспортын гаалийн бүрдүүлэлтийг хариуцна.

**1.3. Тээвэрлэлтийн болон даатгалын гэрээ, хэлэлцээр**

**a) Тээврийн гэрээ**

Худалдагч ачаа барааг нийлүүлэх нэрлэсэн боомтын цэг дээрээс, эсвэл нэрлэсэн очих боомтод хүлээлгэж өгөх газар эсвэл тэр боомт доторхи аливаа тохиролцсон цэг хүртэл ачаа барааг тээвэрлэх тээврийн гэрээг хийх үүрэгтэй.Тээврийн гэрээнд худалдагчийн зардлаар хийж гүйцэтгэх ажлууд, тээвэрлэгчийн тээврийн үйл ажиллагааг хийж гүйцэтгэх гол гол чиглэлүүдийг тусгана.Хэрэв тодорхой цэгийг заагаагүй бол худалдагч нийлүүлэлтийг хийх цэг, нэрлэсэн очих боомтод барааг хүргэх цэгийг өөрт хамгийн тохиромжтойгоор сонгох эрхтэй.

**b) Даатгалын гэрээ**

Худалдагч нь өөрийн зардлаар ачаа барааны даатгалыг хариуцах бөгөөд ингэхдээ ачааны даатгалын С төрлийн эрсдэлд багтдаг хамгийн бага хэмжээний эрсдлүүдийг хариуцах үүрэгтэй.Даатгалын асуудлыг даатгалын байгууллага, даатгуулагч талуудын гэрээгээр шийдвэрлэх бөгөөд даатгалын байгууллага нь худалдан авагчийн нэрлэсэн, нэр хүндтэй байгууллага байж болохоос гадна бараа бүтээгдэхүүнийг даатгах сонирхолтой бусад этгээд ч байж болно.Худалдагч нь худалдан авагчийг түүний шаардсан аливаа мэдээллээр хангах үүрэгтэй бөгөөд ачааны даатгалын А, В төрлийн эрсдлүүдийг даатгахад худалдан авагчийн зардлаар, нэмэлт мэдээллүүдийг өгөх үүрэгтэй.Даатгалын хэмжээ нь хамгийн багадаа гэрээний үнийн дүнгийн 110% тай тэнцэх хэмжээгээр тогтоогдох ба гэрээнд заасан валютаар хийгдэнэ.Даатгал нь барааг нийлүүлэх боомтоос хүрэх боомт хүртлэх бараа бүтээгдэхүүний эрсдлийг

хамарна.Худалдагч нь даатгалын нотолгоо баримтууд, даатгалын үйл ажиллагааны талаархи мэдээллийг худалдан авагчид өгөх үүрэгтэй.Түүнчлэн худалдагч нь худалдан авагчийн эрсдэл, зардлаар аливаа нэмэлт эрсдлүүдийг даатгахад, нэмэлт даатгалын гэрээг байгуулахад худалдан авагчийг мэдээллээр хангах, туслах үүрэгтэй.

#### 1.4. *Нийлүүлэлт*

Гэрээнд заасан хугацаанд барааг тээвэрлэгчид хүлээлгэж өгнө.

#### 1.5. *Эрсдэл шилжих*

Худалдагч нь ачаа барааг гэрээнд заасны дагуу тээвэрлэгчид хүлээлгэж өгөх хүртэл ачаа бараанд учирч болох аливаа алдагдал, эвдрэл гэмтлийн бүх эрсдлийг хариуцна.

#### 1.6. *Зардал хуваарилалт*

Худалдагч дараах зардлуудыг хариуцна. Үүнд:

- a. Ачаа барааг гэрээнд заасан хугацаанд нийлүүлэх нэрлэсэн газар хүртэл хүргэх бараатай холбоотой бүх зардлууд
- b. Тээвэрлэлтийн гэрээг байгуулж, тээврийн хэрэгсэлд ачих, талууд тохиролцсон бол буулгах зардал, тээврийн зардал
- c. Даатгалын гэрээг байгуулж, даатгалын зардал
- d. Экспортын татвар хураамж, гаалийн үзлэг шалгалт, экспортын гаалийн бүрдүүлэлттэй холбоотой бүх зардлыг хариуцаж, төлөх үүрэгтэй.

#### 1.7. *Худалдан авагчид мэдэгдэх*

Худалдан авагчид барааг тээвэрлэгчид хүлээлгэж өгсөн тухайгаа мэдэгдэнэ. Бараа бүтээгдэхүүнийг хүлээн авахад худалдан авагчийн зүгээс хийх боломжтой, шаардлагатай авах арга хэмжээний талаар аливаа мэдээллийг өгөх үүрэгтэй.

#### 1.8. *Нийлүүлэлтийн бичиг баримт*

Худалдагч нь худалдан авагчид нийлүүлэлт, тээвэрлэлтийн баталгаа нотолгоо буюу тээвэрлэлтийн баримт бичгийг өгнө.Тээврийн энэхүү баримт нь худалдааны гэрээнд тусгагдсан байх ёстой бөгөөд барааны нийлүүлэлтийг хүлээн авах хугацааны дотор худалдан авагчид шилжих ёстой.Ингэснээр худалдан авагч нь тээвэрлэлтийн баримт бичгийг

шилжүүлэх буюу тээвэрлэгчид мэдэгдэх замаар транзит замд нь худалдах боломжтой болно. Энэ тээврийн баримтыг гэрээ байдлаар, хэд хэдэн эх хувиар үйлдэх бөгөөд бүх л эх хувиудыг худалдан авагчид танилцуулах ёстой.

#### **1.9. Хянах, савлах, хаяг шошгожуулах**

Худалдагч нь гэрээний дагуу ачаа барааг нийлүүлэхэд шаардагдах хяналт шалгалтын үйл ажиллагаа (үүнд: барааны тоо хэмжээ, чанарыг шалгах, үнэлэх, жинлэх, тоолох) –ны зардлуудыг төлөх үүрэгтэй. Ингэхдээ худалдан авагчаас тээвэрлэлтийн нөхцөл, тээврийн төрлийг урьдчилан хэлсний дагуу (тээврийн төрлийн онцгой хэрэгцээ шаардлага гараагүй л бол) худалдагч барааны сав баглаа боодлыг хариуцна. Сав баглаа боодолд тохирсон хаяг шошгыг хадна.

#### **1.10. Мэдээллийн тусламж, холбогдох зардлууд**

Худалдагч нь худалдан авагчид түүний эрсдэл, зардлаар импортын болон транзит тээвэрлэлтэд шаардлагатай бичиг баримтыг гаргаж өгөх үүрэгтэй. Худалдан авагчийн хүсэлтээр нэмэлт даатгал хийхэд шаардлагатай мэдээллийг өгнө.

### **2. Худалдан авагчийн үүрэг хариуцлага**

#### **2.1. Худалдан авагчийн ерөнхий үүрэг хариуцлага**

Худалдан авагч нь худалдааны гэрээгээр ачаа барааны үнийг төлөх үүрэгтэй.

#### **2.2. Лиценз, зөвшөөрөл, аюулгүй гаалийн бүрдүүлэлт болон бусад дүрэм журмууд**

Худалдан авагч нь барааг импортлоход шаардагдах зөвшөөрөл, лиценз болон бусад шаардлагатай бичиг баримтуудын бүх зардал, эрсдлийг өөрөө хариуцна. Импортын гаалийн бүрдүүлэлтийг өөрийн зардал, эрсдлээр хариуцна.

#### **2.3. Тээвэрлэлтийн болон даатгалын гэрээ, хэлэлциээр**

Худалдагчийн өмнө тээвэрлэлт болон даатгалын ямар нэг үүрэг хүлээхгүй. Худалдагчийн өмнө даатгалын гэрээг байгуулах ямар нэг үүрэг хүлээхгүй. Гэхдээ худалдан авагч шаардлагатай нэмэлт даатгалыг хийлгэхийг хүсвэл энэ талаархи мэдээллийг худалдагчид өгөх үүрэгтэй.

#### 2.4. Нийлүүлэлтийг хүлээн авах

Худалдааны гэрээнд заасан хугацаанд барааны нийлүүлэлтийг нийлүүлэх нэрлэсэн боомтоос тээвэрлэгчээс хүлээн авах үүрэгтэй.

#### 2.5. Эрсдэл шилжих

Барааг ачаалсан боомтоос тээвэрлэгчид хүлээлгэн өгсөн үеэс эхлэн ачаа барааны алдагдал, эвдрэл гэмтлийн аливаа эрсдлийг бүрэн хариуцна. Хэрэв бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийг хүлээн авах газар, хугацааг тодорхой заасан мэдээллийг худалдагчид өгөөгүй бол гэрээнд заасан барааг нийлүүлэх өдрийн хамгийн сүүлчийн өдрөөс эхлэх ачаа барааны бүх эрсдлийг хариуцах үүрэгтэй.

#### 2.6. Зардал хуваарилалт

Худалдан авагч дараах зардлуудыг хариуцна. Үүнд:

- a. Гэрээгээр урьдчилан тохиролцсоны дагуу ачаа бараа эхний тээвэрлэгчид хүлээлгэж өгснөөс эхлэн нэрлэсэн очих газар хүртлэх холбогдох бүхий л нэмэлт зардлууд
- b. Тээврийн гэрээгээр худалдагчийн хариуцахаар тусгасан зардлуудаас бусад бараа бүтээгдэхүүнийг очих боомтод хүлээн авах болон транзит тээвэрлэлттэй холбогдох зардлууд
- c. Очих боомтонд буулгах, жинлэх болон холбогдох бүхий л нэмэлт зардлууд
- d. Барааны нийлүүлэлтийг гэрээгээр тохирсон газар, хугацаанд хүлээж аваагүйгээс үүдэн гарах аливаа хохирлын зардлууд
- e. Худалдан авагчийн хүсэлтээр ачаа барааны нэмэлт эрсдлүүдийг даатгах даатгалын нэмэлт зардлууд
- f. Импортын гаалийн татвар, бусад хураамжууд, импортын үзлэг шалгалтын бүх зардлыг төлнө. Импортын гаалийн бүрдүүлэлтийг хариуцна.

#### 2.7. Худалдагчид мэдээлэх

Хэрэв гэрээний дагуу худалдан авагч ачаалах хугацааг тодорхойлж буюу очих боомтыг заах боломжтой бол худалдагчид зохих мэдээллийг өгнө.

**2.8. Нийлүүлэлтийг хүлээн авсны нотолгоо**

Худалдагчаас өгөх нийлүүлэлтийн буюу тээвэрлэлтийн баримт бичгийг хүлээн авна.

**2.9. Ачаа барааг шалгах**

Экспортын улсын эрх бүхий байгууллагын шаардлагын дагуу тээврийн хэрэгсэлд ачаалахаас өмнө хийгдэх шалгалтын зардлыг төлнө.

**2.10. Мэдээллийн тусламж, холбогдох зардлууд**

Импортлоход шаардлагатай экспортын болон гарал үүслийн баримт бичгийг авах бүх төлбөрийг төлнө. Худалдагчид ийм баримт бичиг гаргасны төлөө төлбөр төлнө.

**IV. DAT –Delivered At Terminal (named terminal at port of destination) буюу  
DAT – Терминал дээр хүргэж өгөх (нэрлэсэн очих/хүрэх боомтын нэрлэсэн терминалын цэг )**

Тус нөхцлөөр худалдагч/үйлдвэрлэгч/экспортлогч нь тээврийн хэрэгслээс буулгасан ачаа барааг нэрлэсэн боомтын эсвэл нийлүүлэх нэрлэсэн газрын нэрлэсэн терминал дээр худалдан авагчийн зөвшөөрсөн цэгт хүлээлгэж өгнө.“Терминал” гэдэгт усан боомт, агуулах, чингэлгийн хашлага, авто зам, төмөр зам, агаарын тээврийн ачааны терминал зэрэг газруудыг хамруулж ойлгоно.

Тус нөхцлийг тээвэрлэлтийн бүх төрөлд хэрэглэнэ.

**DAT нөхцөлөөр худалдагч болон худалдан авагч дараах үүрэг хариуцлагыг хүлээнэ.**

**1 Худалдагчийн үүрэг хариуцлага.**

**1.1. Худалдагчийн ерөнхий үүрэг хариуцлага**

Худалдагч нь худалдааны гэрээний дагуу бараа, барааны худалдааны нэхэмжлэх болон бусад шаардлагатай баримт бичгүүдийг шилжүүлнэ. Худалдагч, худалдан авагч талууд хүлээн зөвшөөрсөн болон

худалдааны практик заншлын дагуу бичиг баримтуудыг электрон байдлаар шилжүүлж болно.

**1.2. Лиценз , зөвшөөрөл, аюулгүй гаалийн бүрдүүлэлт болон бусад дүрэм журмууд**

Худалдагч нь өөрийн зардал, эрсдлээр барааг экспортлоход шаардагдах зөвшөөрөл, лиценз, барааны нийлүүлэлтийг хүргэхээс өмнөх тээвэрлэлтийн үйл ажиллагаатай холбоотой болон экспортлоход шаардлагатай бичиг баримтуудыг олж авах, экспортын гаалийн бүрдүүлэлтийг хариуцна.

**1.3. Тээвэрлэлтийн болон даатгалын гэрээ, хэлэлцээр**

**a) Тээврийн гэрээ**

Худалдагч ачаа барааг нийлүүлэх нэрлэсэн хүрэх газар, эсвэл нэрлэсэн боомтын нэрлэсэн терминал цэг хүртэл тээвэрлэлтийн гэрээг хийж, холбогдох тээврийн зардлыг төлнө. Хэрэв тухайлсан тусгай терминалыг тодорхой заагаагүй бол худалдагч барааг нийлүүлэх нэрлэсэн хүрэх газар, эсвэл нэрлэсэн боомтын нэрлэсэн терминал доторхи хамгийн тохиромжтой цэгийг сонгож ачаа барааг хүргэж өгнө.

**b) Даатгалын гэрээ**

Худалдагч даатгал хийх болон даатгалын зардлыг төлөх үүрэггүй. Харин худалдан авагчид түүний эрсдэл болон зардлаар даатгал олж авахад нь шаардлагатай мэдээллээр хангах, тусламж үзүүлэх үүрэгтэй.

**1.4. Нийлүүлэлт**

Худалдагч гэрээнд заасан хугацааны дотор эсвэл тохиролцсон тодорхой өдөр нэрлэсэн терминалын цэг дээр тээврийн хэрэгслээс ачаа барааг буулгасан байдлаар хүлээлгэж өгөх үүрэгтэй.

**1.5. Эрсдэл шилжих**

Худалдагч нь гэрээнд заасны дагуу ачаа барааг нэрлэсэн терминалын цэг дээр хүлээлгэж өгөх хүртэл ачаа бараанд учирч болох аливаа алдагдал, эвдрэл гэмтлийн бүх эрсдлийг хариуцна.

**1.6. Зардал хуваарилалт**

Худалдагч дараах зардлуудыг хариуцна.Үүнд:

- a. Худалдан авагчийн хариуцах зардлуудаас бусад бүх зардал болон ачаа барааг тээвэрлэхтэй холбоотой тээврийн зардал, бусад нэмэлт зардлууд /ачааг ачих, буулгах зардал/
- b. Экспортын татвар хураамж, гаалийн үзлэг шалгалт, экспортын гаалийн бүрдүүлэлттэй холбоотой бүх зардлыг хариуцаж, төлөх үүрэгтэй.

#### 1.7. *Худалдан авагчид мэдэгдэх*

Худалдан авагчид бараа бүтээгдэхүүнийг хүлээн авахад худалдан авагчийн зүгээс хийх боломжтой, шаардлагатай авах арга хэмжээний талаар аливаа мэдээллийг өгөх үүрэгтэй.

#### 1.8. *Нийлүүлэлтийн бичиг баримт*

Худалдагч нь худалдан авагчид нийлүүлэлт, тээвэрлэлтийн баталгаа нотолгоо буюу тээвэрлэлтийн баримт бичгийг өгнө.Үүнтэй холбоотой зардлыг өөрөө хариуцна.

#### 1.9. *Хянах,савлах, хаяг шошгожуулах*

Худалдагч нь гэрээний дагуу ачаа барааг нийлүүлэхэд шаардагдах хяналт шалгалтын үйл ажиллагаа (үүнд: барааны тоо хэмжээ, чанарыг шалгах, үнэлэх, жинлэх, тоолох) –ны зардлуудыг төлөх үүрэгтэй. Ингэхдээ худалдан авагч худалдагчид тээвэрлэлтийн нөхцөл, тээврийн төрлийг урьдчилан хэлсний дагуу (худалдааны гэрээний худалдан авагч тусгай савлалтын талаар шаардаагүй л бол) худалдагч барааны сав баглаа боодлыг хариуцна.Сав баглаа боодолд тохирсон хаяг шошгыг хадна.

#### 1.10. *Мэдээллийн туссламж, холбогдох зардлууд*

Худалдагч нь худалдан авагчид түүний эрсдэл, зардлаар импортын болон транзит тээвэрлэлтэд шаардлагатай бичиг баримтыг гаргаж өгөх үүрэгтэй.Худалдан авагчийн хүсэлтээр нэмэлт даатгал хийхэд шаардлагатай мэдээллийг өгнө.

### 2 Худалдан авагчийн үүрэг хариуцлага

## **2.1. Худалдан авагчийн өрөнхий үүрэг хариуцлага**

Худалдан авагч нь худалдааны гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу ачаа барааны үнийг төлөх үүрэгтэй.

## **2.2. Лиценз , зөвшөөрөл, аюулгүй гаалийн бүрдүүлэлт болон бусад дүрэм журмууд**

Худалдан авагч нь барааг импортлоход шаардагдах зөвшөөрөл, лиценз болон бусад шаардлагатай бичиг баримтуудын бүх зардал, эрсдлийг өөрөө хариуцна.Импортын гаалийн бүрдүүлэлтийг өөрийн зардал, эрсдлээр хариуцна.

## **2.3. Тээвэрлэлтийн болон даатгалын гэрээ, хэлэлциээр**

Худалдагчийн өмнө тээвэрлэлт болон даатгалын ямар нэг үүрэг хүлээхгүй. Худалдагчийн өмнө даатгалын гэрээг байгуулах ямар нэг үүрэг хүлээхгүй. Харин худалдагчид даатгал хийлгэхэд шаардлагатай нэмэлт мэдээллийг олж авахад туслах үүрэгтэй.

## **2.4. Нийлүүлэлтийг хүлээн авах**

Худалдааны гэрээнд заасан хугацаанд барааны нийлүүлэлтийг нийлүүлэх нэрлэсэн газарт хүргэж ирсэн терминалын цэгээс хүлээн авах үүрэгтэй.

## **2.5. Эрсдэл шилжих**

- a. Худалдан авагч нь нэрлэсэн терминал дээрээс ачаа барааг хүлээн авах үеэс эхлэх бүх эрсдлийг хариуцна.
- b. Худалдан авагч барааг хүлээн авахтай холбоотой импортын зөвшөөрөл лиценз, гаалийн бүрдүүлэлтийн баримт бичгүүдийг олж авч чадаагүй бол түүнээс учрах бүх эрсдлийг хариуцна.
- c. Худалдагчид барааны нийлүүлэлтийг хүлээн авах терминалыг тодорхой заагаагүйгээс гарах бүх эрсдлийг хариуцна.

## **2.6. Зардал хуваарилалт**

Худалдан авагч дараах зардлуудыг хариуцна. Үүнд:

- a. Гэрээгээр урьдчилан тохиролцсоны дагуу ачаа барааг терминалын цэгээс хүлээн авснаас хойших ачаа бараатай холбоотой бүх зардлууд

- b. Барааг хүлээн авахтай холбоотой импортын зөвшөөрөл лиценз, гаалийн бүрдүүлэлтийн баримт бичгүүдийг олж авч чадаагүй бол түүнээс учрах бүх зардал, барааны нийлүүлэлтийг хүлээн авах терминалын цэгийг тодорхой заагаагүйгээс гарах бүх зардлыг хариуцах бөгөөд энэ тухайгаа худалдааны гэрээнд нарийн тодорхой заана.
- c. Импортын гаалийн татвар, бусад хураамжууд, импортын үзлэг шалгалтын бүх зардлыг төлнө. Импортын гаалийн бүрдүүлэлтийг хариуцна.

## 2.7. Худалдагчид мэдээлэх

Худалдан авагч нь барааны нийлүүлэлтийг хүлээн авах хугацааг тодорхой зааж, энэ талаархи хангалттай нотолгоо, мэдээг худалдагчид өгөх үүрэгтэй.

## 2.8. Нийлүүлэлтийг хүлээн авсны нотолгоо

Худалдагчаас өгөх нийлүүлэлтийн буюу тээвэрлэлтийн баримт бичгийг хүлээн авна.

## 2.9. Ачаа барааг шалгах

Экспортын улсын эрх бүхий байгууллагын шаардлагын дагуу тээврийн хэрэгсэлд ачаалахаас өмнө хийгдэх шалгалтын зардлыг төлнө.

## 2.10. Мэдээллийн тусламж, холбогдох зардлууд

Худалдан авагч нь худалдагчийг өөрийн үүргээ биелүүлэхэд шаардлагатай мэдээллээр зөвлөгөө өгөх, тусламж үзүүлэх үүрэгтэй. Бараа бүтээгдэхүүнийг тээвэрлэх, импортлоход шаардлагатай баримт бичгүүдийг олж авахад худалдагчид тусламж үзүүлэх төдийгүй үүнтэй холбоотой худалдагчийн төлсөн зардлуудыг нөхөн төлөх үүрэгтэй.

Харин аливаа улсаар тээвэрлэлтийг зохион байгуулах, бараа бүтээгдэхүүнийг экспортлох, тээвэрлэхэд шаардлагатай аюулгүй байдалтай холбоотой мэдээлэл, баримтуудыг олж авахад худалдагчид туслах үүрэгтэй бөгөөд ингэхдээ худалдагчийн эрсдэл зардлаар энэ үйл ажиллагааг хийж гүйцэтгэнэ.

## V. DAP –Delivered At Place (named place of destination) буюу DAP – (нэрлэсэн газарт хүлээлгэн өгөх )

Тус нөхцлөөр худалдагч/үйлдвэрлэгч/экспортлогч нь нийлүүлэх нэрлэсэн хүрэх газарт тээврийн хэрэгслээс буулгахад бэлэн болсон ачаа барааг худалдан авагчийн зөвшөөрсөн цэгт хүлээлгэж өгнө.Худалдагч барааг нэрлэсэн газарт авчрахтай холбоотой бүх эрсдлийг хариуцна. “Нэрлэсэн хүлээлгэж өгөх газар” нь худалдан авагчийн нутаг дэвсгэр байна.

Тус нөхцлийг тээвэрлэлтийн бүх төрөлд хэрэглэнэ.

**DAP нөхцөлөөр худалдагч болон худалдан авагч дараах үүрэг хариуцлагыг хүлээнэ.**

## **1 Худалдагчийн үүрэг хариуцлага.**

### **1.1. Худалдагчийн ерөнхий үүрэг хариуцлага**

Худалдагч нь худалдааны гэрээний дагуу бараа, барааны худалдааны нэхэмжлэх болон бусад шаардлагатай баримт бичгүүдийг шилжүүлнэ.Худалдагч, худалдан авагч талууд тохиролцвол бичиг баримтуудыг электрон байдлаар шилжүүлж болно.

### **1.2. Лиценз , зөвшөөрөл, аюулгүй гаалийн бүрдүүлэлт болон бусад дүрэм журмууд**

Худалдагч нь өөрийн зардал, эрсдлээр барааг экспортлоход шаардагдах зөвшөөрөл, лиценз, бусад баримт бичгүүдийг олж авна.Мөн барааны нийлүүлэлтийг хүргэхээс өмнөх тээвэрлэлтийн үйл ажиллагаатай холбоотой болон экспортлоход шаардлагатай бичиг баримтуудын бүрдүүлэлт, экспортын гаалийн бүрдүүлэлтийг хариуцна.

### **1.3. Тээвэрлэлтийн болон даатгалын гэрээ, хэлэлцээр**

#### **a) Тээврийн гэрээ**

Худалдагч ачаа барааг нийлүүлэх нэрлэсэн хүрэх газар хүртэл тээвэрлэлтийн гэрээг хийж, холбогдох тээврийн зардлыг төлнө.Хэрэв тухайлсан тусгай цэгийг тодорхой заагаагүй бол худалдагч барааг нийлүүлэх нэрлэсэн хүрэх газрын доторхи хамгийн тохиромжтой цэгийг сонгож ачаа барааг хүргэж өгнө.

#### **b) Даатгалын гэрээ**

Худалдагч даатгал хийх болон даатгалын зардлыг төлөх үүрэггүй. Харин худалдан авагчид түүний эрсдэл болон зардлаар даатгал олж авахад нь шаардлагатай мэдээллээр хангах, тусламж үзүүлэх үүрэгтэй.

#### *1.4. Нийлүүлэлт*

Худалдагч гэрээнд заасан хугацааны дотор эсвэл тохиролцсон тодорхой өдөр нэрлэсэн цэг дээр худалдан авагчид тээврийн хэрэгслээс буулгахад бэлэн болсон ачааг хүлээлгэж өгөх үүрэгтэй.

#### *1.5. Эрсдэл шилжих*

Худалдагч нь гэрээнд заасны дагуу ачаа барааг нэрлэсэн цэг дээр хүлээлгэж өгөх хүртэл ачаа бараанд учирч болох аливаа алдагдал, эвдрэл гэмтлийн бүх эрсдлийг хариуцна.

#### *1.6. Зардал хуваарилалт*

Худалдагч дараах зардлуудыг хариуцна.Үүнд:

- a. Худалдан авагчийн хариуцах зардлуудаас бусад бүх зардал болон ачаа барааг тээвэрлэхтэй холбоотой тээврийн зардал, бусад нэмэлт зардлууд /ачааг ачих, тээвэрлэлтийн гэрээгээр худалдагч хариуцахаар заасан бол буулгах зардал/
- b. Экспортын татвар хураамж, гаалийн үзлэг шалгалт, экспортын гаалийн бүрдүүлэлттэй холбоотой бүх зардлыг хариуцаж, төлөх үүрэгтэй.

#### *1.7. Худалдан авагчид мэдээгдэх*

Худалдан авагчид бараа бүтээгдэхүүнийг хүлээн авахад худалдан авагчийн зүгээс хийх боломжтой, шаардлагатай авах арга хэмжээний талаар аливаа мэдээллийг өгөх үүрэгтэй.

#### *1.8. Нийлүүлэлтийн бичиг баримт*

Худалдагч нь худалдан авагчид нийлүүлэлт, тээвэрлэлтийн баталгаа нотолгоо буюу тээвэрлэлтийн баримт бичгийг өгнө.Үүнтэй холбоотой зардлыг өөрөө хариуцна.

#### *1.9. Хянах, савлах, хаяг шошгожуулах*

Худалдагч нь гэрээний дагуу ачаа барааг нийлүүлэхэд шаардагдах хяналт шалгалтын үйл ажиллагаа (үүнд: барааны тоо хэмжээ, чанарыг шалгах,

үнэлэх, жинлэх, тоолох) –ны зардлуудыг төлөх үүрэгтэй. Ингэхдээ худалдан авагч нь тээвэрлэлтийн нөхцөл, тээврийн төрлийг урьдчилан хэлсний дагуу (худалдааны гэрээний дагуу худалдан авагч тусгай савлалтын талаар шаардаагүй л бол) худалдагч барааны сав баглаа боодлыг хариуцна. Сав баглаа боодолд тохирсон хаяг шошгыг хадна.

#### **1.10. Мэдээллийн тусламж, холбогдох зардлууд**

Худалдагч нь худалдан авагчид түүний эрсдэл, зардлаар импортын болон транзит тээвэрлэлтэд шаардлагатай гарал үүслийн бичиг баримтыг гаргаж өгөх үүрэгтэй. Худалдан авагчийн хүсэлтээр нэмэлт даатгал хийхэд шаардлагатай мэдээллийг өгнө. Бараа бүтээгдэхүүнийг экспортлоход шаардлагатай мэдээлэл, баримтуудыг худалдан авагчийн зардлаар олж авсан тохиолдолд эдгээр зардлыг худалдан авагчид буцаан төлөх үүрэгтэй.

## **2 Худалдан авагчийн үүрэг хариуцлага**

#### **2.1. Худалдан авагчийн өрөнхий үүрэг хариуцлага**

Худалдан авагч нь худалдааны гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу ачаа барааны үнийг төлөх үүрэгтэй.

#### **2.2. Лиценз , зөвшөөрөл, аюулгүй гаалийн бүрдүүлэлт болон бусад дүрэм журмууд**

Худалдан авагч нь барааг импортлоход шаардагдах зөвшөөрөл, лиценз болон бусад шаардлагатай бичиг баримтуудын бүх зардал, эрсдлийг өөрөө хариуцна. Импортын гаалийн бүрдүүлэлтийг өөрийн зардал, эрсдлээр хариуцна.

#### **2.3. Тээвэрлэлтийн болон даатгалын гэрээ, хэлэлциээр**

Худалдагчийн өмнө тээвэрлэлт болон даатгалын ямар нэг үүрэг хүлээхгүй. Харин худалдагчид даатгал хийлгэхэд шаардлагатай нэмэлт мэдээллийг олж авахад туслах үүрэгтэй.

#### **2.4. Нийлүүлэлтийг хүлээн авах**

Худалдааны гэрээнд заасан хугацаанд барааны нийлүүлэлтийг хүргэж ирсэн нэрлэсэн цэгээс хүлээн авах үүрэгтэй.

## **2.5. Эрсдэл шилжих**

- a. Худалдан авагч нь нэрлэсэн цэг дээрээс ачаа барааг хүлээн авах үеэс эхлэх бүх эрсдлийг хариуцна.
- b. Худалдан авагч барааг хүлээн авахтай холбоотой импортын зөвшөөрөл лиценз, гаалийн бүрдүүлэлтийн баримт бичгүүдийг олж авч чадаагүй бол түүнээс учрах бүх эрсдлийг хариуцна.
- c. Худалдагчид барааны нийлүүлэлтийг хүлээн авах цэгийг тодорхой заагаагүйгээс гарах бүх эрсдлийг хариуцна.

## **2.6. Зардал хуваарилалт**

Худалдан авагч дараах зардлуудыг хариуцна. Үүнд:

- a. Гэрээгээр урьдчилан тохиролцсоны дагуу ачаа барааг нийлүүлэх нэрлэсэн газрын нэрлэсэн цэгээс хүлээн авснаас хойших ачаа бараатай холбоотой бүх зардлууд
- b. Тээврийн гэрээнд худалдагч хариуцахаар заагаагүй бол нэрлэсэн нийлүүлэх цэг дээр тээврийн хэрэгслээс ачаа барааг буулгах зардал
- c. Барааг хүлээн авахтай холбоотой импортын зөвшөөрөл лиценз, гаалийн бүрдүүлэлтийн баримт бичгүүдийг олж авч чадаагүй бол түүнээс учрах бүх зардал, барааны нийлүүлэлтийг хүлээн авах цэгийг тодорхой заагаагүйгээс гарах бүх зардлыг хариуцах бөгөөд энэ тухайгаа худалдааны гэрээнд нарийн тодорхой заана.
- d. Импортын гаалийн татвар, бусад хураамжууд, импортын үзлэг шалгалтын бүх зардлыг төлнө.Импортын гаалийн бүрдүүлэлтийг хариуцна.

## **2.7. Худалдагчид мэдээлэх**

Худалдан авагч нь барааны нийлүүлэлтийг хүлээн авах хугацааг тодорхой зааж, энэ талаархи хангалттай нотолгоо, мэдээг худалдагчид өгөх үүрэгтэй.

## **2.8. Нийлүүлэлтийг хүлээн авсны нотолгоо**

Худалдагчаас өгөх нийлүүлэлтийн буюу тээвэрлэлтийн баримт бичгийг хүлээн авна.

## **2.9. Ачаа барааг шалгах**

Экспортын улсын эрх бүхий байгууллагын шаардлагын дагуу тээврийн хэрэгсэлд ачаалахаас өмнө хийгдэх шалгалтын зардлыг төлнө.

#### *2.10. Мэдээллийн тусламж, холбогдох зардлууд*

Худалдан авагч нь худалдагчийг өөрийн үүргээ биелүүлэхэд шаардлагатай мэдээллээр зөвлөгөө өгөх, тусламж үзүүлэх үүрэгтэй. Бараа бүтээгдэхүүнийг тээвэрлэх, импортлоход шаардлагатай баримт бичгүүдийг олж авахад худалдагчид тусламж үзүүлэх төдийгүй үүнтэй холбоотой худалдагчийн төлсөн зардлуудыг нөхөн төлөх үүрэгтэй. Харин аливаа улсаар тээвэрлэлтийг зохион байгуулах, бараа бүтээгдэхүүнийг экспортлох, тээвэрлэхэд шаардлагатай аюулгүй байдалтай холбоотой мэдээлэл, баримтуудыг олж авахад худалдагчид туслах үүрэгтэй бөгөөд ингэхдээ худалдагчийн эрсдэл зардлаар энэ үйл ажиллагааг хийж гүйцэтгэнэ.

### **VI. DDP –DELIVERED DUTY PAID (named place of destination) буюу DAP – Нийлүүлэлтийн төлбөр төлөгдсөн (нэрлэсэн хүрэх газар)**

Тус нөхцлөөр худалдагч/үйлдвэрлэгч/экспортлогч нь ачаа барааны экспортын бүрдүүлэлтийг хийж, импортын гаалийн үзлэгт орсон боловч тээврийн хэрэгслээс буулгаагүй барааг нэрлэсэн газарт худалдан авагчид хүлээлгэн өгнө.

Тус нөхцлийг тээвэрлэлтийн бүх төрөлд хэрэглэнэ. Худалдагч барааг нэрлэсэн газарт авчрахтай холбоотой бүх эрсдлийг хариуцах бөгөөд барааны экспортын гаалийн бүрдүүлэлтийг хийгээд зогсохгүй мөн импортын гаалийн бүрдүүлэлтийг хариуцаж, экспорт импортын бүх татвар хураамжийг төлөх үүрэгтэй. “Нийлүүлэх нэрлэсэн газар” нь худалдан авагчийн нутаг дэвсгэр байна.

DDP нөхцөл нь худалдагчийн үүрэг хариуцлага хамгийн их байх нөхцөл юм.

**DDP нөхцөлөөр худалдагч болон худалдан авагч дараах үүрэг хариуцлагыг хүлээнэ.**

#### **1 Худалдагчийн үүрэг хариуцлага.**

##### *1.1. Худалдагчийн ерөнхий үүрэг хариуцлага*

Худалдагч нь худалдааны гэрээний дагуу бараа, барааны худалдааны нэхэмжлэх болон бусад шаардлагатай баримт бичгүүдийг шилжүүлнэ. Худалдагч, худалдан авагч талууд тохиролцвол бичиг баримтуудыг электрон байдлаар шилжүүлж болно.

1.2. *Лиценз, зөвшөөрөл, аюулгүй гаалийн бүрдүүлэлт болон бусад дүрэм журмууд*

Худалдагч нь өөрийн зардал, эрсдлээр барааг экспортлох, импортлоход шаардагдах зөвшөөрөл, лиценз, бусад баримт бичгүүдийг олж авна. Мөн барааны нийлүүлэлтийг хүргэхээс өмнөх тээвэрлэлтийн үйл ажиллагаатай холбоотой болон экспортлоход шаардлагатай бичиг баримтуудын бүрдүүлэлт, экспорт, импортын гаалийн бүрдүүлэлтийг хариуцна.

1.3. *Тээвэрлэлтийн болон даатгалын гэрээ, хэлэлциээр*

a) Тээврийн гэрээ

Худалдагч ачаа барааг нийлүүлэх нэрлэсэн хүрэх газар хүртэл тээвэрлэлтийн гэрээг хийж, холбогдох тээврийн зардлыг төлнө. Хэрэв тухайлсан тусгай цэгийг тодорхой заагаагүй бол худалдагч барааг нийлүүлэх нэрлэсэн хүрэх газрын доторхи хамгийн тохиромжтой цэгийг сонгож ачаа барааг хүргэж өгнө.

b) Даатгалын гэрээ

Худалдагч даатгал хийх болон даатгалын зардлыг төлөх үүрэггүй. Харин худалдан авагчид түүний эрсдэл болон зардлаар даатгал олж авахад нь шаардлагатай мэдээллээр хангах, тусlamж үзүүлэх үүрэгтэй.

1.4. *Нийлүүлэлт*

Худалдагч гэрээнд заасан хугацааны дотор эсвэл тохиролцсон тодорхой өдөр нэрлэсэн цэг дээр тээврийн хэрэгслээс буулгахад бэлэн болсон ачааг худалдан авагчид хүлээлгэж өгөх үүрэгтэй.

1.5. *Эрсдэл шилжих*

Худалдагч нь гэрээнд заасны дагуу ачаа барааг нэрлэсэн цэг дээр хүлээлгэж өгөх хүртэл ачаа бараанд учирч болох аливаа алдагдал, эвдрэл гэмтлийн бүх эрсдлийг хариуцна.

## *1.6. Зардал хуваарилалт*

Худалдагч дараах зардлуудыг хариуцна. Үүнд:

- a. Худалдан авагчийн хариуцах зардлуудаас бусад бүх зардал болон ачаа барааг тээвэрлэхтэй холбоотой тээврийн зардал, бусад нэмэлт зардлууд /ачааг ачих, тээвэрлэлтийн гэрээгээр худалдагч хариуцахаар заасан бол буулгах зардал/
- b. Экспорт, импортын татвар хураамж, гаалийн үзлэг шалгалт, экспортын гаалийн бүрдүүлэлттэй холбоотой бүх зардлыг хариуцаж, төлөх үүрэгтэй.

## *1.7. Худалдан авагчид мэдээгдэх*

Худалдан авагчид бараа бүтээгдэхүүнийг хүлээн авахад худалдан авагчийн зүгээс хийх боломжтой, шаардлагатай авах арга хэмжээний талаар аливаа мэдээллийг өгөх үүрэгтэй.

## *1.8. Нийлүүлэлтийн бичиг баримт*

Худалдагч нь худалдан авагчид нийлүүлэлт, тээвэрлэлтийн баталгаа нотолгоо буюу тээвэрлэлтийн баримт бичгийг өгнө. Үүнтэй холбоотой зардлыг өөрөө хариуцна.

## *1.9. Хянах, савлах, хаяг шошгожуулах*

Худалдагч нь гэрээний дагуу ачаа барааг нийлүүлэхэд шаардагдах хяналт шалгалтын үйл ажиллагаа (үүнд: барааны тоо хэмжээ, чанарыг шалгах, үнэлэх, жинлэх, тоолох) –ны зардлуудыг төлөх үүрэгтэй. Ингэхдээ худалдан авагч нь тээвэрлэлтийн нөхцөл, тээврийн төрлийг урьдчилан хэлсний дагуу (худалдааны гэрээний дагуу худалдан авагч тусгай савалалтын талаар шаардаагүй л бол) худалдагч барааны сав баглаа боодлыг хариуцна. Сав баглаа боодлод тохирсон хаяг шошгыг хадна.

## *1.10. Мэдээллийн туссламж, холбогдох зардлууд*

Худалдагч нь худалдан авагчид түүний эрсдэл, зардлаар импортын болон транзит тээвэрлэлтэд шаардлагатай мэдээлэл, баримтыг гаргаж өгөх үүрэгтэй. Бараа бүтээгдэхүүний мэдээлэл, баримтуудыг худалдан авагчийн

зардлаар олж авсан тохиолдолд эдгээр зардлыг худалдан авагчид буцаан төлөх үүрэгтэй.

## **2 Худалдан авагчийн үүрэг хариуцлага**

### **2.1. Худалдан авагчийн өрөнхий үүрэг хариуцлага**

Худалдан авагч нь худалдааны гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу ачаа барааны үнийг төлөх үүрэгтэй.

### **2.2. Лиценз , зөвшөөрөл, аюулгүй гаалийн бүрдүүлэлт болон бусад дүрэм журмууд**

Худалдан авагч нь барааг импортлоход шаардагдах зөвшөөрөл, лиценз болон бусад шаардлагатай бичиг баримтуудыг олж авахад нь худалдагчид туслах үүрэгтэй бөгөөд энэ үйл ажиллагааг худалдагчийн эрсдэл, зардлаар хийж гүйцэтгэнэ.

### **2.3. Тээвэрлэлтийн болон даатгалын гэрээ, хэлэлциээр**

Худалдагчийн өмнө тээвэрлэлт болон даатгалын ямар нэг үүрэг хүлээхгүй.Харин худалдагчид даатгал хийлгэхэд шаардлагатай нэмэлт мэдээллийг олж авахад туслах үүрэгтэй.

### **2.4. Нийлүүлэлтийг хүлээн авах**

Худалдааны гэрээнд заасан хугацаанд барааны нийлүүлэлтийг нэрлэсэн цэгээс хүлээн авах үүрэгтэй.

### **2.5. Эрсдэл шилжих**

- a. Худалдан авагч нь нэрлэсэн цэг дээрээс ачаа барааг хүлээн авах үеэс эхлэх бүх эрсдлийг хариуцна.
- b. Худалдагчид ачаа барааны импортын зөвшөөрөл лиценз, гаалийн бүрдүүлэлтийн баримт бичгүүдийг олж авахад нь тусlamж үзүүлж чадаагүй бол түүнээс учрах бүх эрсдлийг хариуцна.
- c. Худалдагчид барааны нийлүүлэлтийг хүлээн авах цэг, хугацааг тодорхой заагаагүйгээс гарах бүх эрсдлийг хариуцна.

### **2.6. Зардал хуваарилалт**

Худалдан авагч дараах зардлуудыг хариуцна. Үүнд:

- a. Гэрээгээр урьдчилан тохиролцсоны дагуу ачаа барааг нэрлэсэн цэгээс хүлээн авснаас хойших ачаа бараатай холбоотой бүх зардлууд
- b. Тээврийн гэрээнд худалдагч хариуцахаар заагаагүй бол нэрлэсэн нийлүүлэх цэг дээр тээврийн хэрэгслээс ачаа барааг буулгах зардал
- c. Худалдагчид ачаа барааны импортын зөвшөөрөл лиценз, гаалийн бүрдүүлэлтийн баримт бичгүүдийг олж авахад нь тусlamж үзүүлж чадаагүй бол түүнээс учрах бүх зардал, барааны нийлүүлэлтийг хүлээн авах цэг, хугацааг тодорхой заагаагүйгээс гарах бүх зардлыг хариуцах бөгөөд энэ тухайгаа худалдааны гэрээнд нарийн тодорхой заана.

## 2.7. *Худалдагчид мэдээлэх*

Худалдан авагч нь барааны нийлүүлэлтийг хүлээн авах хугацааг тодорхой зааж, энэ талаархи хангалттай нотолгоо, мэдээг худалдагчид өгөх үүрэгтэй.

## 2.8. *Нийлүүлэлтийг хүлээн авсны нотолгоо*

Худалдагчаас өгөх нийлүүлэлтийн буюу тээвэрлэлтийн баримт бичгийг хүлээн авна.

## 2.9. *Ачаа барааг шалгах*

Экспортын болон импортын улсын эрх бүхий байгууллагын шаардлагын дагуу тээврийн хэрэгсэлд ачаалахаас өмнө хийгдэх шалгалтын зардлуудыг худалдагчийн өмнөөс төлөх үүрэггүй.

## 2.10. *Мэдээллийн тусlamж, холбогдох зардлууд*

Худалдан авагч нь худалдагчийг өөрийн үүргээ биелүүлэхэд шаардлагатай мэдээллээр хангах, түүнд зөвлөгөө өгөх, тусlamж үзүүлэх үүрэгтэй. Бараа бүтээгдэхүүнийг тээвэрлэх, экспортлох, импортлоход шаардлагатай баримт бичгүүдийг олж авахад худалдагчид тусlamж үзүүлэх төдийгүй үүнтэй холбоотой худалдагчийн төлсөн зардлуудыг нөхөн төлөх үүрэгтэй.

Харин аливаа улсаар тээвэрлэлтийг зохион байгуулах, бараа бүтээгдэхүүнийг импортлох, экспортлох, тээвэрлэхэд шаардлагатай аюулгүй байдалтай холбоотой мэдээлэл, баримтуудыг олж авахад худалдагчид туслах үүрэгтэй бөгөөд ингэхдээ худалдагчийн эрсдэл зардлаар энэ үйл ажиллагааг хийж гүйцэтгэнэ.

## **“ДАЛАЙН ТЭЭВЭРТ АШИГЛАГДАГ НӨХЦЛҮҮД”**

### **I. FAS-Free Alongside Ship (named port of shipment) буюу FAS-Усан онгоцны хашлагын дагуу чөлөөтэй (нэрлэсэн газар нь илгээх боомт )**

Энэ нөхцөлөөр худалдагч/экспортлогч/ үйлдвэрлэгч нь ачаа барааг “ачаалах/илгээх боомт”-ны тавцанд буюу усан онгоцны хашлагын дагуу хүргэнэ. Нэрлэсэн нийлүүлэх газар буюу ачаалах боомт нь худалдагчийн улсын газар байна. Талууд нэрлэсэн ачаалах боомт дээр ачаа барааг ачих цэгийг маш тодорхой нарийн тохиролцох шаардлагатай, учир нь тухайн цэг дээрээс худалдагчийн хариуцах зардал, эрсдэл болон бусад холбогдох үүргүүд худалдан авагчид шилжих юм. Бараа бүтээгдэхүүнийг чингэлэгт савласан тохиолдолд худалдагч нь усан онгоцны хашлагын дагуу бус терминал дээр тээвэрлэгчид барааг шилжүүлнэ. Энэ тохиолдолд FAS нөхцөл тохиромжтой бус харин FCA нөхцлийг хэрэглэж болно.

Энэ нөхцөл нь зөвхөн далайн ба дотоодын усан замын тээвэрт хэрэглэгдэнэ.

FAS нөхцлөөр худалдагч барааны экспортын гаалийн бүрдүүлэлтийг хариуцна. Гэхдээ барааны импортын гаалийн бүрдүүлэлтийг хариуцах үүрэггүй, импортын аливаа татвар хураамжийг төлөхгүй.

**FAS нөхцөлөөр худалдагч болон худалдан авагч дараах үүрэг хариуцлагыг хүлээнэ.**

## 1 Худалдагчийн үүрэг хариуцлага.

### 1.1. Худалдагчийн өрөнхий үүрэг хариуцлага

Худалдагч нь худалдааны гэрээний дагуу бараа, барааны худалдааны нэхэмжлэх болон бусад шаардлагатай баримт бичгүүдийг шилжүүлнэ.Худалдагч, худалдан авагч талууд хүлээн зөвшөөрсөн болон худалдааны практик заншлын дагуу бичиг баримтуудыг электрон байдлаар шилжүүлж болно.

### 1.2. Лиценз , зөвшөөрөл, аюулгүй гаалийн бүрдүүлэлт болон бусад дүрэм журмууд

Худалдагч нь өөрийн зардал, эрсдлээр барааны экспортын зөвшөөрөл, лиценз болон бусад шаардлагатай бичиг баримтуудыг олж авах болон барааг экспортлоход шаардлагатай гаалийн бүх бүрдүүлэлтийг хариуцна.

### 1.3. Тээвэрлэлтийн болон даатгалын гэрээ, хэлэлцээр

#### a) Тээврийн гэрээ

Худалдагч нь ачаа барааг тээвэрлэж хүлээлгэх ямар ч үүрэггүй.Өөрөөр хэлбэл тээврийн гэрээг байгуулахгүй. Гэсэн хэдий ч худалдан авагчийн хүсэлтээр эсвэл худалдааны практик туршлагаар худалдан авагчийн эрсдэл, зардлаар онцгой нөхцлөөр тээвэрлэлтийн гэрээг байгуулж болно.Аль ч тохиолдолд худалдагч тээврийн гэрээг хийхээс татгалзаж болно, энэ тухайгаа худалдан авагчид түргэн мэдээлэх ёстой.

#### b) Даатгалын гэрээ

Худалдагч нь худалдан авагчид даатгалын гэрээг байгуулах ямар ч үүрэггүй. Гэхдээ худалдан авагчийн хүсэлтээр, түүний зардал эрсдлээр даатгалын гэрээ байгуулж, даатгал хийлгэхэд шаардлагатай бүхий л мэдээллээр худалдан авагчийг хангах үүрэгтэй.

### 1.4. Нийлүүлэлт

Гэрээнд заасан хугацаанд барааг нэрлэсэн нийлүүлэх газарт нэрлэсэн усан онгоцны боомтын тавцны дагуу хүргэж өгөх үүрэгтэй.Хэрэв худалдан авагч ачаалах цэгийг тодорхой заагаагүй бол худалдагч нэрлэсэн ачаалах боомтоос хамгийн тохиромжтой цэгийг сонгож болно.Хэрэв талууд нийлүүлэлтийг тодорхой хугацааны дотор хийж гүйцэтгэнэ гэж тохиролцсон бол худалдан авагч нь тухайн тохиролцсон хугацааны дотор тодорхой нэг өдрийг сонгох эрхтэй.

#### 1.5. Эрсдэл шилжих

Худалдагч нь ачаа барааг гэрээнд заасан хугацаанд нэрлэсэн нийлүүлэх газарт нэрлэсэн боомтод хүргэх хүртэл ачаа бараанд учирч болох аливаа алдагдал, эвдрэл гэмтлийн бүх эрсдлийг хариуцна.

#### 1.6. Зардал хуваарилалт

Худалдагч нь ачаа барааг гэрээнд заасан хугацаанд нэрлэсэн нийлүүлэх газарт нэрлэсэн боомтод хүргэж өгөх болон экспортын татвар хураамж, гаалийн үзлэг шалгалт, экспортын гаалийн бүрдүүлэлттэй холбоотой бүх зардлыг хариуцаж, төлөх үүрэгтэй.

#### 1.7. Худалдан авагчид мэдэгдэх

Нэрлэсэн усан онгоцны дагуу барааг хүргэх тухайгаа худалдан авагчид мэдэгдэнэ. Мөн худалдан авагчийн эрсдэл, зардлаар нийлүүлэлтийн нөхцлийн дагуу барааг хүргэж өгсөн болон усан онгоц тохиролцсон хугацаанд барааг аваагүй талаархи хангалттай нотолгоог худалдан авагчид өгөх үүрэгтэй.

#### 1.8. Нийлүүлэлтийн бичиг баримт

Худалдагч нь өөрийн зардлаар худалдан авагчид барааг нийлүүлсэн тухай нотлох баримтуудыг өгөх үүрэгтэй.Хэрэв иймэрхүү нотолгоо нь тээврийн баримт биш бол худалдан авагчийн хүсэлт, түүний эрсдэл, зардлаар холбогдох тээвэрлэлтийн баримт бичгийг олоход худалдан авагчид туслалцаа үзүүлнэ.

#### 1.9. Хянах, савлах, хаяг шошгожуулах

Худалдагч нь гэрээний дагуу ачаа барааг нийлүүлэхэд шаардагдах хяналт шалгалтын үйл ажиллагаа (үүнд: барааны тоо хэмжээ, чанарыг шалгах,

үнэлэх, жинлэх, тоолох) –ны зардлуудыг төлөх үүрэгтэй. Ингэхдээ худалдан авагч худалдагчид тээвэрлэлтийн нөхцөл, тээврийн төрлийг урьдчилан хэлсний дагуу (тээврийн төрлийн онцгой хэрэгцээ шаардлага гараагүй л бол) худалдагч барааны сав баглаа боодлыг хариуцна. Сав баглаа боодолд тохирсон хаяг шошгыг хадна.

#### *1.10. Мэдээллийн тусламж, холбогдох зардлууд*

Худалдагч нь худалдан авагчийн хүсэлтээр түүний зардал, эрсдлээр экспортын орны гаргах баримт бичиг буюу импортын болон транзит тээвэрлэлтэд шаардлагатай гарал үүслийн бичиг баримтыг гаргаж өгөх үүрэгтэй. Худалдан авагчийн хүсэлтээр даатгал хийхэд шаардлагатай мэдээллийг өгнө. Худалдагч нь худалдан авагчийн хүссэн мэдээлэл, баримт бичгийг олж авахад тусламж үзүүлэх, мэдээллээр хангахдаа худалдан авагчийн зарцуулсан бүх зардлыг шаардлагатай тохиолдолд буцаан нөхөн олгох ёстой.

## **2 Худалдан авагчийн үүрэг хариуцлага**

### *2.1. Худалдан авагчийн ерөнхий үүрэг хариуцлага*

Худалдан авагч нь худалдааны гэрээг бүрэн төгс ханган биелүүлэхийн тулд ачаа барааны үнийг төлөх үүрэгтэй.

### *2.2. Лиценз , зөвшөөрөл, аюулгүй гаалийн бүрдүүлэлт болон бусад дүрэм журмууд*

Худалдан авагч нь барааг импортлоход шаардагдах зөвшөөрөл, лиценз болон бусад шаардлагатай бичиг баримтуудын бүх зардал, эрсдлийг өөрөө хариуцна. Импортын гаалийн бүрдүүлэлтийг өөрийн зардал, эрсдлээр хариуцна.

### *2.3. Тээвэрлэлтийн болон даатгалын гэрээ, хэлэлциээр*

#### a) Тээврийн гэрээ

Худалдан авагч нь ачаалах нэрлэсэн боомтоос барааг тээвэрлэх тээврийн гэрээг байгуулна, түүнтэй холбоотой тээврийн зардлыг хариуцна.

#### b) Даатгалын гэрээ

Худалдан авагч нь заавал даатгалын гэрээг хийх албагүй. Гэхдээ даатгал хийлгэхээр болсон тохиолдолд өөрийн зардлаар даатгал хийлгэхэд шаардлагатай бүхий л мэдээллийг олж авч, даатгалын гэрээг байгуулж болно.

#### 2.4. *Нийлүүлэлтийг хүлээн авах*

Худалдааны гэрээнд заасан хугацаанд нэрлэсэн нийлүүлэх боомтоос барааны нийлүүлэлтийг хүлээн авах үүрэгтэй.

#### 2.5. *Эрсдэл шилжих*

Худалдааны гэрээгээр тохиролцсон хугацаанд, нэрлэсэн нийлүүлэх газраас ачаа бараа усан онгоцны дагуу хүргэсэн мөчөөс эхлэн ачаа барааны алдагдал, эвдрэл гэмтлийн аливаа эрсдлийг бүрэн хариуцна.

Хэрэв,

- a. Худалдан авагч нь усан онгоцны нэр, ачаалах цэг, нийлүүлэлтийн хугацаа зэргийг худалдагчид мэдээлэгүй бол
- b. Худалдан авагчийн нэрлэсэн усан онгоц цагтаа хүрч очоогүй, барааг ачаалаагүй бол тохиролцсон өдрөөс эсвэл нийлүүлэх хугацаа дуусах өдрөөс эхлэн барааны эвдрэл гэмтэл, алдагдал зэрэг бүх эрсдлийг хариуцна.

#### 2.6. *Зардал хуваарилалт*

Худалдан авагч дараах зардлуудыг хариуцна. Үүнд:

- a. Гэрээгээр урьдчилан тохиролцсоны дагуу ачаа бараа усан онгоцны дагуу хүргэсэн мөчөөс эхлэх ачаа бараатай холбоотой тээвэрлэлт, даатгалын бүх зардлыг төлнө.
- b. Гэрээнд заасан хугацаанд ачаа барааг нэрлэсэн усан онгоц ирээгүйгээс учирсан хохирлыг төлнө.
- c. Импортын гаалийн татвар, бусад хураамжууд, импортын үзлэг шалгалтын бүх зардлыг төлнө. Импортын гаалийн бүрдүүлэлтийг хариуцна.

#### 2.7. *Худалдагчид мэдээлэх*

Худалдагчид усан онгоцны нэр, барааг ачих цэг, шаардлагатай тохиолдолд нийлүүлэх цаг хугацааны талаархи хангалттай мэдээллийг өгөх үүрэгтэй.

**2.8. Нийлүүлэлтийг хүлээн авсны нотолгоо**

Худалдагчаас өгөх нийлүүлэлтийн буюу тээвэрлэлтийн баримт бичгийг хүлээн авна.

**2.9. Ачаа барааг шалгах**

Экспортын улсын эрх бүхий байгууллагаас хийдэг шалгалтаас гадна заавал хийгдэх ачаалахаас өмнөх хяналт шалгалтын зардлыг төлнө.

**2.10. Мэдээллийн тусламж, холбогдох зардлууд**

Импортлоход шаардлагатай экспортын болон гарал үүслийн баримт бичгийг авах бүх төлбөрийг төлнө. Худалдагчид ийм баримт бичиг гаргасны төлөө төлбөр төлнө.

**VII. FOB-Free On Board (named port of shipment) буюу FOB-Усан онгоцны тавцангаас чөлөөтэй (нэрлэсэн газар нь илгээх боомт )**

Энэ нөхцөлөөр худалдагч/экспортлогч/ үйлдвэрлэгч нь ачаа барааг “ачаалах/илгээх боомт”-оос худалдан авагчийн нэрлэсэн усан онгоцны тавцан дээр тавих үүрэг хүргэнэ. Нэрлэсэн нийлүүлэх газар буюу ачаалах боомт нь худалдагчийн улсын газар байна. Усан онгоцны тавцан дээр бараа бүтээгдэхүүнийг тавиж шилжүүлсэн үеэс бараа бүтээгдэхүүнтэй холбоотой бүх эрсдэл худалдагчаас худалдан авагчид шилжинэ.

Энэ нөхцөл нь зөвхөн далайн ба дотоодын усан замын тээвэрт хэрэглэгдэнэ.

**FOB нөхцөлөөр худалдагч болон худалдан авагч дараах үүрэг хариуцлагыг хүлээнэ.**

**1 Худалдагчийн үүрэг хариуцлага.**

**1.1. Худалдагчийн ерөнхий үүрэг хариуцлага**

Худалдагч нь худалдааны гэрээний дагуу бараа, барааны худалдааны нэхэмжлэх болон бусад шаардлагатай баримт бичгүүдийг шилжүүлнэ. Худалдагч, худалдан авагч талууд хүлээн зөвшөөрсөн болон худалдааны практик заншлын дагуу бичиг баримтуудыг электрон байдлаар шилжүүлж болно.

**1.2. Лиценз , зөвшөөрөл, аюулгүй гаалийн бүрдүүлэлт болон бусад дүрэм журмууд**

Худалдагч нь өөрийн зардал, эрсдлээр барааг экспортлоход шаардагдах зөвшөөрөл, лиценз болон бусад шаардлагатай бичиг баримтууд болон экспортын гаалийн бүрдүүлэлтийг хариуцна.

**1.3. Тээвэрлэлтийн болон даатгалын гэрээ, хэлэлцээр**

**a) Тээврийн гэрээ**

Худалдагч нь барааг тээвэрлэж хүлээлгэх ямар ч үүрэггүй.Өөрөөр хэлбэл тээврийн гэрээг байгуулахгүй. Гэсэн хэдий ч худалдан авагч хүсвэл, эсвэл энэ нь худалдааны гэрээгээр тохиролцсон бол худалдан авагч тээвэрлэлтийн эсрэг зааварчилгааг өгөөгүй л бол худалдагч худалдан авагчийн эрсдэл, зардлаар тээвэрлэлтийн гэрээг байгуулж болно. Аль ч тохиолдолд худалдагч тээвэрлэлтийн гэрээ байгуулахаас татгалзаж болох бөгөөд энэ тухай худалдан авагчид даруй мэдэгдэх хэрэгтэй.

**b) Даатгалын гэрээ**

Худалдагч нь даатгалын гэрээг байгуулах ямар ч үүрэггүй. Гэхдээ худалдан авагчийн хүсэлтээр, түүний зардал эрсдлээр даатгалын гэрээ байгуулж, даатгал хийлгэхэд шаардлагатай бүхий л мэдээллийг олж авахад туслах Үүрэгтэй.

**1.4. Нийлүүлэлт**

Гэрээнд заасан хугацаанд барааг нэрлэсэн нийлүүлэх газарт нэрлэсэн усан онгоцны тавцан хүртэл хүргэж өгнө.Хэрэв ачаалах тусгай цэгийг худалдан авагч заагаагүй бол худалдагч барааг нийлүүлэх нэрлэсэн боомтын доторхи хамгийн тохиромжтой цэгийг сонгож болно.

**1.5. Эрсдэл шилжих**

Худалдагч нь ачаа барааг гэрээнд заасан хугацаанд нэрлэсэн нийлүүлэх газарт нэрлэсэн боомтод нэрлэсэн усан онгоцны тавцанд шилжүүлснээр ачаа бараанд учирч болох аливаа алдагдал, эвдрэл гэмтлийн бүх эрсдлийг хариуцна.

**1.6. Зардал хуваарилалт**

Худалдагч дараах зардлуудыг хариуцна. Үүнд:

- a. Ачаа барааг гэрээнд заасан хугацаанд нэрлэсэн нийлүүлэх газарт нэрлэсэн боомтны нэрлэсэн усан онгоцны тавцанд хүргэж өгөх зардал,
- b. Экспортын татвар хураамж, гаалийн үзлэг шалгалт, экспортын гаалийн бүрдүүлэлттэй холбоотой бүх зардлыг хариуцаж, төлөх үүрэгтэй.

#### **1.7. Худалдан авагчид мэдэгдэх**

Нэрлэсэн усан онгоцны тавцанд барааг шилжүүлснээ худалдан авагчид мэдэгдэнэ. Мөн худалдан авагчийн эрсдэл зардлаар барааны нийлүүлэлтийг тохиролцсны дагуу хийж гүйцэтгэх болон тохиролцсон хугацаанд тээвэрлэгч барааны нийлүүлэлтийг хүлээн аваагүй талаар хангалттай нотолгоо, мэдээллийг худалдан авагчид өгөх үүрэгтэй.

#### **1.8. Нийлүүлэлтийн бичиг баримт**

Худалдагч нь өөрийн зардлаар худалдан авагчид нийлүүлэлтийн баталгаа нотолгоо буюу тээвэрлэлтийн баримт бичгийг өгөх бөгөөд энэ баримт нь хангалттай нотолгоо баримт биш бол холбогдох тээвэрлэлтийн баримт бичгийг олоход худалдан авагчийн зардал, эрсдлээр худалдан авагчид туслалцаа үзүүлнэ.

#### **1.9. Хянах, савлах, хаяг шошгожуулах**

Худалдагч нь гэрээний дагуу ачаа барааг нийлүүлэхэд шаардагдах хяналт шалгалтын үйл ажиллагаа (үүнд: барааны тоо хэмжээ, чанарыг шалгах, үнэлэх, жинлэх, тоолох) –ны зардлуудыг төлөх үүрэгтэй. Ингэхдээ худалдан авагч худалдагчид тээвэрлэлтийн нөхцөл, тээврийн төрлийг урьдчилан хэлсний дагуу (тээврийн төрлийн онцгой хэрэгцээ шаардлага гараагүй л бол) худалдагч барааны сав баглаа боодлыг хариуцна. Сав баглаа боодолд тохирсон хаяг шошгыг хадна.

#### **1.10. Мэдээллийн тусламж, холбогдох зардлууд**

Худалдагч нь худалдан авагчийн хүсэлтээр түүний зардал, эрсдлээр экспортын орны гаргах баримт бичиг буюу импортын болон транзит тээвэрлэлтэд шаардлагатай гарал үүслийн бичиг баримт, бараа бүтээгдэхүүний аюулгүй байдалтай холбоотой мэдээлэл, баримтуудыг олж авахад худалдан авагчид туслалцаа үзүүлэх үүрэгтэй. Худалдан авагчийн хүсэлтээр даатгал хийхэд шаардлагатай мэдээллийг өгнө.

## **2 Худалдан авагчийн үүрэг хариуцлага**

### **2.1. Худалдан авагчийн өрөнхий үүрэг хариуцлага**

Худалдан авагч нь худалдааны гэрээгээр тохиролцсны дагуу ачаа барааны үнийг төлөх үүрэгтэй.

### **2.2. Лиценз , зөвшөөрөл, аюулгүй гаалийн бүрдүүлэлт болон бусад дүрэм журмууд**

Худалдан авагч нь аливаа улсаар дамжин хийгдэх тээвэрлэлт, бараа бүтээгдэхүүнийг импортлоход шаардагдах гаалийн бүх бүрдүүлэлтийг хийх, зөвшөөрөл, лиценз болон бусад шаардлагатай бичиг баримтуудыг өөрийн зардал, эрсдлээр хариуцан , олж авах үүрэгтэй.

### **2.3. Тээвэрлэлтийн болон даатгалын гэрээ, хэлэлциээр**

#### **a) Тээврийн гэрээ**

Худалдан авагч нь ачаа барааг усан онгоцонд ачаалах нэрлэсэн нийлүүлэх боомтоос бараа бүтээгдэхүүнийг тээвэрлэх тээврийн гэрээ байгуулж, тээвэрлэхтэй холбоотой бүх эрсдэл, зардлыг хариуцна.

#### **b) Даатгалын гэрээ**

Худалдан авагч нь заавал даатгалын гэрээг хийх албагүй. Гэхдээ даатгал хийлгэхээр болсон тохиолдолд өөрийн зардлаар даатгал хийлгэхэд шаардлагатай бүхий л мэдээллийг олж авч, даатгалын гэрээг байгуулж болно.

### **2.4. Нийлүүлэлтийг хүлээн авах**

Худалдааны гэрээнд заасан хугацаанд нэрлэсэн нийлүүлэх боомтын усан онгоцны тавцангaaас барааны нийлүүлэлтийг хүлээн авах үүрэгтэй.

### **2.5. Эрсдэл шилжих**

Худалдааны гэрээгээр тохиролцсон хугацаанд, нэрлэсэн нийлүүлэх газраас ачаа бараа усан онгоцны тавцанд хүрсэн мөчөөс эхлэн ачаа барааны алдагдал, эвдрэл гэмтлийн аливаа эрсдлийг бүрэн хариуцна.

Хэрэв:

- a. Худалдан авагч нь гэрээгээр тохиролцсон хугацаанаас нийлүүлэлтийн хугацаа, ачаалах цэг, усан онгоцны нэр зэрэг хангалттай мэдээллийг худалдагчид өгөх үүргийн дагуу усан онгоцны нэрийг заагаагүй,
- b. Худалдан авагчийн нэрлэсэн усан онгоц худалдагчийн бараа нийлүүлэлтийг гүйцэтгэх боломжит хугацаанд, яг тохирсон цагтаа хүрч очоогүй эсвэл бараа бүтээгдэхүүнийг авах боломжгүй нөхцөл байдал өөрөөр хэлбэл тохирсон хугацаанаас өмнө ачааг авахаар ирсэн, тохиолдлуудад худалдан авагч бараа бүтээгдэхүүний эвдрэл, гэмтэл, алдагдалтай холбоотой бүх эрсдлийг дараах хугацаанаас эхлэн хариуцна:
  - ✓ Тохиролцсон хугацаанаас,
  - ✓ Худалдагчийн барааг нийлүүлэхээр сонгосон хугацаанаас,
  - ✓ Гэрээгээр тохиролцсон нийлүүлэлтийн хугацаа дуусах өдрөөс,

## 2.6. Зардал хуваарилалт

Худалдан авагч дараах зардлуудыг хариуцна. Үүнд:

- a. Гэрээгээр урьдчилан тохиролцсоны дагуу ачаа бараа усан онгоцны тавцанд гарсан үеэс эхлэх ачаа бараатай холбоотой тээвэрлэлт, даатгалын бүх зардлыг төлнө.
- b. Гэрээнд заасан хугацаанд нэрлэсэн нийлүүлэх газарт барааны нийлүүлэлтийг хүлээж аваагүйгээс учирсан хохирлыг төлнө.
- c. Импортын гаалийн татвар, импортын болон транзит тээврийн бусад хураамжууд, импортын үзлэг шалгалтын бүх зардлыг төлнө. Импортын гаалийн бүрдүүлэлтийг хариуцна.

## 2.7. Худалдаачид мэдээлэх

Худалдан авагч нь гэрээгээр тохиролцсон хугацаанаас сонгосон нийлүүлэлтийн хугацаа, ачаалах цэг, усан онгоцны нэр зэрэг хангалттай мэдээллийг худалдагчид өгнө.

## 2.8. Нийлүүлэлтийг хүлээн авсны нотолгоо

Худалдагчаас өгөх нийлүүлэлтийн буюу тээвэрлэлтийн баримт бичгийг хүлээн авна.

## 2.9. Ачаа барааг шалгах

Экспортын улсын эрх бүхий байгууллагын шаардлагын дагуу тээврийн хэрэгсэлд ачаалахаас өмнө хийгдэх шалгалтын зардлыг төлнө.

#### 2.10. *Мэдээллийн тусламж, холбоодох зардлууд*

Худалдан авагч худалдагчийн хүсэлтээр, түүний эрсдэл зардлаар бараа бүтээгдэхүүний аюулгүй байдалтай холбоотой тухайлбал тээвэрлэлт, барааг экспортлох, транзит тээвэртэй холбоотой аливаа мэдээлэл, баримтыг олж авахад худалдагчид туслах үүрэгтэй.Шаардлагатай тохиолдолд худалдагчийн гаргасан зардлыг нөхөн олгоно.

### **VIII. CFR –Cost and Freight (named port of destination) буюу CFR- Зардал ба Тээвэрлэлт (нэрлэсэн очих/хүрэх боомт )**

Энэ нөхцөлөөр худалдагч/экспортлогч/ үйлдвэрлэгч нь ачаа барааг “нэрлэсэн очих/хүрэх боомт”-ны усан онгоцны тавцан хүртэл хүргэж өгнө.Усан онгоцны тавцан дээр бараа бүтээгдэхүүнийг тавиж шилжүүлсэн үеэс бараа бүтээгдэхүүнтэй холбоотой бүх эрсдэл худалдагчаас худалдан авагчид шилжинэ.Худалдагч нь очих боомт хүртлэх тээвэрлэлттэй холбоотой зардлыг хариуцна.

Энэ нөхцөл нь зөвхөн далайн ба дотоодын усан замын тээвэрт хэрэглэгдэнэ.Тус нөхцлийн “нэрлэсэн очих/хүрэх боомт” нь худалдан авагчийн улсын газар байна.

**CFR нөхцөлөөр худалдагч болон худалдан авагч дараах үүрэг хариуцлагыг хүлээнэ.**

#### **1. Худалдагчийн үүрэг хариуцлага.**

##### **1.1. Худалдагчийн ерөнхий үүрэг хариуцлага**

Худалдагч нь худалдааны гэрээний дагуу бараа, барааны худалдааны нэхэмжлэх болон бусад шаардлагатай баримт бичгүүдийг шилжүүлнэ.Худалдагч, худалдан авагч талууд хүлээн зөвшөөрсөн болон худалдааны практик заншлын дагуу бичиг баримтуудыг электрон байдлаар шилжүүлж болно.

##### **1.2. Лиценз , зөвшөөрөл, аюулгүй гаалийн бүрдүүлэлт болон бусад дүрэм журмууд**

Худалдагч нь өөрийн зардал, эрсдлээр барааг экспортлоход шаардагдах зөвшөөрөл, лиценз болон бусад шаардлагатай бичиг баримтууд болон экспортын бүрдүүлэлтийг хариуцна.

### **1.3. Тээвэрлэлтийн болон даатгалын гэрээ, хэлэлцээр**

#### **a) Тээврийн гэрээ**

Худалдагч нь нэрлэсэн хүрэх боомт хүртэл тээвэрлэлтийн гэрээг хийх үүрэгтэй. Тээврийн гэрээгээр тээвэрлэх бараа бүтээгдэхүүний төрөлд тохирсон тээврийн хэрэгсэл, усан онгоцны чиглэлийн талаархи мэдээллийг худалдагч хангах үүрэг хүлээх бөгөөд тээврийн бүх зардлыг хариуцна.

#### **b) Даатгалын гэрээ**

Худалдагч нь худалдан авагчид даатгалын гэрээг байгуулах ямар ч үүрэггүй. Гэхдээ худалдан авагчийн хүсэлтээр, түүний зардал эрсдлээр даатгалын гэрээ байгуулж, даатгал хийлгэхэд шаардлагатай бүхий л мэдээллийг олж авахад нь худалдан авагчид туслах үүрэгтэй.

### **1.4. Нийлүүлэлт**

Гэрээнд заасан хугацаанд барааг нэрлэсэн нийлүүлэх боомтын нэрлэсэн усан онгоцны тавцанд хүргэж өгнө.

### **1.5. Эрсдэл шилжих**

Худалдагч нь ачаа барааг гэрээнд заасан хугацаанд нэрлэсэн нийлүүлэх газарт /ачаалах боомт/ нэрлэсэн усан онгоцны тавцангас нийлүүлэх хүртэл ачаа бараанд учирч болох аливаа алдагдал, эвдрэл гэмтлийн бүх эрсдлийг хариуцна.

### **1.6. Зардал хуваарилалт**

Худалдагч дараах зардлуудыг хариуцан, төлөх үүрэгтэй. Үүнд:

- a. Ачаа барааг гэрээнд заасан хугацаанд нэрлэсэн ачаалах боомтод нэрлэсэн усан онгоцны тавцанд хүргэж өгөхтэй холбоотой зардал,
- b. Нэрлэсэн хүрэх боомт хүртлэх тээвэрлэлт, ачих зардал
- c. Экспортын татвар хураамж, гаалийн үзлэг шалгалт, экспортын гаалийн бүрдүүлэлттэй холбоотой бүх зардлыг хариуцаж, төлөх үүрэгтэй.

### **1.7. Худалдан авагчид мэдэгдэх**

Худалдан авагчид барааг нэрлэсэн усан онгоцонд ачсан тухайгаа мэдэгдэнэ. Худалдагч нь бараа бүтээгдэхүүнийг хүлээн авах хүртэл аливаа

шаардлагатай арга хэмжээнүүдийг авах талаар худалдан авагчид мэдээлнэ.

**1.8. Нийлүүлэлтийн бичиг баримт**

Худалдагч нь худалдан авагчид нийлүүлэлт, тээвэрлэлтийн баталгаа нотолгоо буюу тээвэрлэлтийн баримт бичгийг өгөх бөгөөд холбогдох тээвэрлэлтийн баримт бичгийг олоход худалдан авагчид туслалцаа үзүүлнэ. Ингэснээр худалдан авагч нь тээвэрлэлтийн баримт бичгийг шилжүүлэх буюу тээвэрлэгчид мэдэгдэх замаар транзит замд нь худалдах боломжтой болно. Энэ тээврийн баримтыг гэрээ байдлаар, хэд хэдэн эх хувиар үйлдэх бөгөөд бүх л эх хувиудыг худалдан авагчид танилцуулах ёстой.

**1.9. Хянах, савлах, хаяг шошгожуулах**

Худалдагч нь гэрээний дагуу ачаа барааг нийлүүлэхэд шаардагдах хяналт шалгалтын үйл ажиллагаа (үүнд: барааны тоо хэмжээ, чанарыг шалгах, үнэлэх, жинлэх, тоолох) –ны зардлуудыг төлөх үүрэгтэй. Ингэхдээ худалдан авагч худалдагчид тээвэрлэлтийн нөхцөл, тээврийн төрлийг урьдчилан хэлсний дагуу (тээврийн төрлийн онцгой хэрэгцээ шаардлага гараагүй л бол) худалдагч барааны сав баглаа боодлыг хариуцна. Сав баглаа боодолд тохирсон хаяг шошгыг хадна.

**1.10. Мэдээллийн тусламж, холбогдох зардлууд**

Худалдагч нь худалдан авагчийн хүсэлтээр түүний зардал, эрсдлээр экспортын орны гаргах баримт бичиг буюу импортын болон транзит тээвэрлэлтэд шаардлагатай гарал үүслийн бичиг баримтыг гаргаж өгөх үүрэгтэй. Худалдан авагчийн хүсэлтээр даатгал хийхэд шаардлагатай мэдээллийг өгнө.

**2. Худалдан авагчийн үүрэг хариуцлага**

**2.1. Худалдан авагчийн ерөнхий үүрэг хариуцлага**

Худалдан авагч нь худалдааны гэрээнд заасны дагуу ачаа барааны үнийг төлөх үүрэгтэй.

**2.2. Лиценз , зөвшөөрөл, аюулгүй гаалийн бүрдүүлэлт болон бусад дүрэм журмууд**

Худалдан авагч нь барааг импортлоход шаардагдах зөвшөөрөл, лиценз болон бусад шаардлагатай бичиг баримтуудын бүх зардал, эрсдлийг өөрөө хариуцна. Импортын гаалийн бүрдүүлэлтийг өөрийн зардал, эрсдлээр хариуцна.

#### 2.3. Тээвэрлэлтийн болон даатгалын гэрээ, хэлэлциээр

Худалдагчийн өмнө тээвэрлэлт болон даатгалын гэрээ байгуулах ямар нэг үүрэг хүлээхгүй. Гэхдээ хүсвэл худалдагчийг даатгал олж авахад шаардлагатай мэдээллээр хангах үүрэгтэй.

#### 2.4. Нийлүүлэлтийг хүлээн авах

Худалдааны гэрээнд заасан хугацаанд хүргэж ирсэн боомт (нийлүүлэх нэрлэсэн боомт) дээр тээвэрлэгчээс барааны нийлүүлэлтийг хүлээн авах үүрэгтэй.

#### 2.5. Эрсдэл шилжих

Барааг худалдагчийн улсын нэрлэсэн ачаалах боомт дээр усан онгоцны тавцанд гарсан үеэс эхлэн ачаа барааны алдагдал, эвдрэл гэмтлийн аливаа эрсдлийг бүрэн хариуцна.

#### 2.6. Зардал хуваарилалт

Худалдан авагч дараах зардлуудыг хариуцна. Үүнд:

- a. Гэрээгээр урьдчилан тохиролцсоны дагуу ачаа бараа усан онгоцны тавцанд гарсан үеэс эхлэх бараа бүтээгдэхүүнтэй холбоотой бүх зардлууд,
- b. Очих боомтонд буулгах, жинлэх болон тээврийн гэрээгээр худалдагчийн хариуцахаар зааснаас бусад нэмэлт зардлууд,
- c. Барааг нийлүүлэхээр тохиролцсон хугацаа дуусахаас өмнө, эсвэл яг тохиролцсон хугацаанд барааг нийлүүлэгүйгээс гарах хохирол, торгуулийн зардал
- d. Тээврийн гэрээгээр худалдагчийн хариуцах зардлуудад ороогүй л бол нэрлэсэн очих боомт хүртлэх транзит тээврээр барааг тээвэрлэхтэй холбоотой бүх зардал, хураамжууд,

е. Импортын гаалийн татвар, бусад хураамжууд, импортын үзлэг шалгалтын бүх зардлыг төлнө. Импортын гаалийн бүрдүүлэлтийг хариуцна.

#### 2.7. Худалдагчид мэдээлэх

Нэрлэсэн хүрэх боомтын дотор барааг хүлээн авах цэг эсвэл барааг усан онгоцонд ачих хугацааг тодорхой зааж худалдагчид энэ талаархи хангалттай мэдээллийг өгөх ёстой.

#### 2.8. Нийлүүлэлтийг хүлээн авсны нотолгоо

Худалдагчаас өгөх нийлүүлэлтийн буюу тээвэрлэлтийн баримт бичгийг хүлээн авна.

#### 2.9. Ачаа барааг шалгах

Экспортын улсын эрх бүхий байгууллагаас хийгдэх аливаа шалгалтаас гадна тэдгээрийн шаардлагын дагуу тээврийн хэрэгсэлд ачаалахаас өмнө хийгдэх шалгалтын зардлыг төлнө.

#### 2.10. Мэдээллийн тусламж, холбогдох зардлууд

Импортлоход шаардлагатай экспортын болон гарал үүслийн баримт бичгийг авах бүх төлбөрийг төлнө.Худалдагчид ийм баримт бичиг гаргасны төлөө төлбөр төлнө.Худалдан авагч худалдагчийн хүсэлтээр, түүний эрсдэл зардлаар бараа бүтээгдэхүүний аюулгүй байдалтай холбоотой тухайлбал тээвэрлэлт, барааг экспортлох, транзит тээвэртэй холбоотой аливаа мэдээлэл, баримтыг олж авахад худалдагчид туслах үүрэгтэй.Шаардлагатай тохиолдолд худалдагчийн гаргасан зардлыг нөхөн олгоно.

### IX. CIF –Cost and Insurance and Freight (named port of destination) буюу CIF- Зардал Даатгал ба Тээвэрлэлт (нэрлэсэн очих/хүрэх боомт )

Энэ нөхцөлөөр худалдагч/экспортлогч/ үйлдвэрлэгч нь ачаа барааг “нэрлэсэн очих/хүрэх боомт”-ны усан онгоцны зогсоол хүртэл хүргэж өгнө.Худалдагч нь очих боомт хүртлэх тээвэрлэлттэй холбоотой зардлыг хариуцна.Ачаа бараа усан онгоцны тавцан дээр тавигдсан үеэс ачаа барааны аливаа эрсдэл худалдагчаас худалдан

авагчид шилжинэ.Худалдагч нэрлэсэн очих боомт хүртэл ачаа барааг тээвэрлэх үүргийг хүлээж, зардлыг төлнө.

Энэ нөхцөл нь зөвхөн далайн ба дотоодын усан замын тээвэрт хэрэглэгдэнэ.

**CIF нөхцөлөөр худалдагч болон худалдан авагч дараах үүрэг хариуцлагыг хүлээнэ.**

## **1 Худалдагчийн үүрэг хариуцлага.**

### **1.1. Худалдагчийн өрөнхий үүрэг хариуцлага**

Худалдагч нь худалдааны гэрээний дагуу бараа, барааны худалдааны нэхэмжлэх болон бусад шаардлагатай баримт бичгүүдийг шилжүүлнэ.Худалдагч, худалдан авагч талууд хүлээн зөвшөөрсөн болон худалдааны практик заншлын дагуу бичиг баримтуудыг электрон байдлаар шилжүүлж болно.

### **1.2. Лиценз , зөвшөөрөл, аюулгүй гаалийн бүрдүүлэлт болон бусад дүрэм журмууд**

Худалдагч нь өөрийн зардал, эрсдлээр барааг экспортлоход шаардагдах зөвшөөрөл, лиценз болон бусад шаардлагатай бичиг баримтууд болон экспортын гаалийн бүрдүүлэлтийг хариуцна.

### **1.3. Тээвэрлэлтийн болон даатгалын гэрээ, хэлэлцээр**

#### **a) Тээврийн гэрээ**

Худалдагч ачаа барааг нийлүүлэх нэрлэсэн боомтын цэг дээрээс, эсвэл нэрлэсэн очих боомтод хүлээлгэж өгөх газар эсвэл тэр боомт доторхи аливаа тохиролцсон цэг хүртэл ачаа барааг тээвэрлэх тээврийн гэрээг хийх үүрэгтэй.Тээврийн гэрээгээр тээвэрлэх бараа бүтээгдэхүүний төрөлд тохирсон тээврийн хэрэгсэл, усан онгоцны чиглэлийн талаархи мэдээллийг худалдагч хангах үүрэг хүлээх бөгөөд тээврийн бүх зардлыг хариуцна.

#### **b) Даатгалын гэрээ**

Худалдагч нь өөрийн зардлаар ачаа барааны даатгалыг хариуцах бөгөөд ингэхдээ ачааны даатгалын С төрлийн эрсдэлд багтдаг хамгийн бага хэмжээний эрсдлүүдийг хариуцах үүрэгтэй.Даатгалын асуудлыг даатгалын байгууллага, даатгуулагч талуудын гэрээгээр шийдвэрлэх бөгөөд даатгалын байгууллага нь худалдан авагчийн нэрлэсэн, нэр хүндтэй

байгууллага байж болохоос гадна бараа бүтээгдэхүүнийг даатгах сонирхолтой бусад этгээд ч байж болно.

Худалдагч нь худалдан авагчийг түүний шаардсан аливаа мэдээллээр хангах үүрэгтэй бөгөөд ачааны даатгалын А, В төрлийн эрсдлүүдийг даатгахад худалдан авагчийн зардлаар, нэмэлт мэдээллүүдийг өгөх үүрэгтэй. Даатгалын хэмжээ нь хамгийн багадаа гэрээний үнийн дүнгийн 110% тай тэнцэх хэмжээгээр тогтоогдох ба гэрээнд заасан валютаар хийгдэнэ. Даатгал нь барааг нийлүүлэх боомтоос хүрэх боомт хүртлэх бараа бүтээгдэхүүний эрсдлийг хамарна. Худалдагч нь худалдан авагчид даатгалын нотолгоо баримтууд, даатгалын үйл ажиллагааны талаархи мэдээллийг өгөх үүрэгтэй. Түүнчлэн худалдагч нь худалдан авагчийн эрсдэл, зардлаар аливаа нэмэлт эрсдлүүдийг даатгахад, нэмэлт даатгалын гэрээг байгуулахад худалдан авагчийг мэдээллээр хангах, туслах үүрэгтэй.

#### 1.4. Нийлүүлэлт

Гэрээнд заасан хугацаанд барааг нийлүүлэх нэрлэсэн боомтын нэрлэсэн усан онгоцны тавцанд хүргэж өгөх бөгөөд нэрлэсэн очих боомт хүртлэх нийлүүлэлтийн зардлыг хариуцна.

#### 1.5. Эрсдэл шилжих

Худалдагч нь ачаа барааг гэрээнд заасны дагуу ачаалах боомтны нэрлэсэн усан онгоцны тавцанд нийлүүлэх хүртэл ачаа бараанд учирч болох аливаа алдагдал, эвдрэл гэмтлийн бүх эрсдлийг хариуцна.

#### 1.6. Зардал хуваарилалт

Худалдагч дараах зардлуудыг хариуцна. Үүнд:

- Ачаа барааг гэрээнд заасан хугацаанд нэрлэсэн хүрэх боомт хүртэл хүргэх бараатай холбоотой бүх зардлууд
- Тээвэрлэлтийн гэрээг байгуулж, тээврийн хэрэгсэлд ачих, талууд тохиролцсон бол буулгах зардал, тээврийн зардал
- Даатгалын гэрээг байгуулж, даатгалын зардал
- Экспортын татвар хураамж, гаалийн үзлэг шалгалт, экспортын гаалийн бүрдүүлэлттэй холбоотой бүх зардлыг хариуцаж, төлөх үүрэгтэй.

#### 1.7. Худалдан авагчид мэдэгдэх

Худалдан авагчид барааг нэрлэсэн усан онгоцонд ачсан тухайгаа мэдэгдэнэ. Бараа бүтээгдэхүүнийг хүлээн авахад худалдан авагчийн зүгээс хийх боломжтой, шаардлагатай авах арга хэмжээний талаар аливаа мэдээллийг өгөх үүрэгтэй.

#### 1.8. Нийлүүлэлтийн бичиг баримт

Худалдагч нь худалдан авагчид нийлүүлэлт, тээвэрлэлтийн баталгаа нотолгоо буюу тээвэрлэлтийн баримт бичгийг өгөх бөгөөд холбогдох тээвэрлэлтийн баримт бичгийг олоход худалдан авагчид туслалцаа үзүүлнэ. Ингэснээр худалдан авагч нь тээвэрлэлтийн баримт бичгийг шилжүүлэх буюу тээвэрлэгчид мэдэгдэх замаар транзит замд нь худалдах боломжтой болно. Энэ тээврийн баримтыг гэрээ байдлаар, хэд хэдэн эх хувиар үйлдэх бөгөөд бүх л эх хувиудыг худалдан авагчид танилцуулах ёстой.

#### 1.9. Хянах, савлах, хаяг шошгожуулах

Худалдагч нь гэрээний дагуу ачаа барааг нийлүүлэхэд шаардагдах хяналт шалгалтын үйл ажиллагаа (үүнд: барааны тоо хэмжээ, чанарыг шалгах, үнэлэх, жинлэх, тоолох) –ны зардлуудыг төлөх үүрэгтэй. Ингэхдээ худалдан авагч тээвэрлэлтийн нөхцөл, тээврийн төрлийг урьдчилан хэлсний дагуу (тээврийн төрлийн онцгой хэрэгцээ шаардлага гарагүй л бол) худалдагч барааны сав баглаа боодлыг хариуцна. Сав баглаа боодолд тохирсон хаяг шошгыг хадна.

#### 1.10. Мэдээллийн тусламж, холбогдох зардлууд

Худалдагч нь худалдан авагчид импортын болон транзит тээвэрлэлтэд шаардлагатай гарал үүслийн бичиг баримтыг гаргаж өгөх үүрэгтэй. Худалдан авагчийн хүсэлтээр даатгал хийхэд шаардлагатай мэдээллийг өгнө.

### 2 Худалдан авагчийн үүрэг хариуцлага

#### 2.1. Худалдан авагчийн ерөнхий үүрэг хариуцлага

Худалдан авагч нь худалдааны гэрээг бүрэн төгс ханган биелүүлэхийн тулд ачаа барааны үнийг төлөх үүрэгтэй.

**2.2. Лиценз , зөвшөөрөл, аюулгүй гаалийн бүрдүүлэлт болон бусад дүрэм журмууд**

Худалдан авагч нь барааг импортлоход шаардагдах зөвшөөрөл, лиценз болон бусад шаардлагатай бичиг баримтуудын бүх зардал, эрсдлийг өөрөө хариуцна.Импортын гаалийн бүрдүүлэлтийг өөрийн зардал, эрсдлээр хариуцна.

**2.3. Тээвэрлэлтийн болон даатгалын гэрээ, хэлэлцээр**

- a. Худалдагчийн өмнө тээврийн гэрээг байгуулах,тээвэрлэлт хийх үүрэг хүлээхгүй.
- b. Худалдагчийн өмнө даатгалын гэрээг байгуулах ямар нэг үүрэг хүлээхгүй. Гэхдээ худалдан авагч шаардлагатай нэмэлт даатгалыг хийлгэхийг хүсвэл энэ талаархи мэдээллийг худалдагчид өгөх үүрэгтэй.

**2.4. Нийлүүлэлтийг хүлээн авах**

Худалдааны гэрээнд заасан хугацаанд барааны нийлүүлэлтийг нийлүүлэх нэрлэсэн боомтоос хүлээн авах үүрэгтэй.

**2.5. Эрсдэл шилжих**

Барааг ачаалсан боомтоос усан онгоцны тавцанд гарсан үеэс эхлэн ачаа барааны алдагдал, эвдрэл гэмтлийн аливаа эрсдлийг бүрэн хариуцна.Хэрэв бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийг хүлээн авах газар, хугацааг тодорхой заасан мэдээллийг худалдагчид өгөөгүй бол гэрээнд заасан барааг нийлүүлэх өдрийн хамгийн сүүлчийн өдрөөс ачаа барааны бүх эрсдлийг хариуцах үүрэгтэй.

**2.6. Зардал хуваарилалт**

Худалдан авагч дараах зардлуудыг хариуцна. Үүнд:

- a. Гэрээгээр урьдчилан тохиролцсоны дагуу ачаа бараа усан онгоцны тавцанд гарсан үеэс эхлэх аливаа нэмэлт зардлууд
- b. Тээврийн гэрээгээр худалдагчийн хариуцахаар тусгасан зардлуудаас бусад бараа бүтээгдэхүүнийг нийлүүлэх нэрлэсэн боомтод хүлээн авах болон транзит тээвэрлэлттэй холбогдох зардлууд
- c. Хүрэх боомтонд буулгах, жинлэх болон холбогдох бүхий л нэмэлт зардлууд

- d. Барааны нийлүүлэлтийг гэрээгээр тохирсон газар, хугацаанд хүлээж аваагүйгээс үүдэн гарах аливаа хохирлын зардлууд
  - e. Худалдан авагчийн хүсэлтээр ачаа барааны нэмэлт эрсдлүүдийг даатгах даатгалын нэмэлт зардлууд
  - f. Импортын гаалийн татвар, бусад хураамжууд, импортын үзлэг шалгалтын бүх зардлыг төлнө. Импортын гаалийн бүрдүүлэлтийг хариуцна.
- 2.7. *Худалдагчид мэдээлэх*  
Худалдан авагч нийлүүлэх нэрлэсэн боомтод барааг хүлээж авах тохиромжтой цэг, барааны нийлүүлэлтийг хүлээн авах хугацааг нарийн тодорхойлж энэ талаархи хангалттай мэдээллийг худалдагчид өгөх үүрэгтэй.
- 2.8. *Нийлүүлэлтийг хүлээн авсны нотолгоо*  
Худалдагчаас өгөх нийлүүлэлтийн буюу тээвэрлэлтийн баримт бичгийг хүлээн авна.
- 2.9. *Ачаа барааг шалгах*  
Экспортын улсын эрх бүхий байгууллагын шаардлагын дагуу тээврийн хэрэгсэлд ачаалахаас өмнө хийгдэх шалгалтын зардлыг төлнө.
- 2.10. *Мэдээллийн тусламж, холбогдох зардлууд*  
Импортлоход шаардлагатай экспортын болон гарал үүслийн баримт бичгийг авах бүх төлбөрийг төлнө. Худалдагчид ийм баримт бичиг гаргасны төлөө төлбөр төлнө.